

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.03.21, МЯГМАР ~ №051 (597)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР
АН-ын дотоод сонгуульд өрсөлдөгч 565 хүн нэр дэвшигчийн үнэмлэхээ гардав.
УИХ-ын дарга энэ сарын 26-нд Японд айлчилж, санхүүгийн дэмжлэгийн талаар ярилцана.
Чехэд суух Элчин сайд Н.Наранбат ноён Милош Земанд итгэмжлэх жуухаа барив.
АН-ын дарга С.Эрдэнэ “Манай нам фракцгүй, цоо шинэ нам болон төлөвшино” хэмээлээ.

ЭДИЙН ЗАСАГ
Монголбанкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 759.7 тэрбум төгрөг болов.
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрт 34.3 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.
Хөрөнгийн биржийн индекс 847.19 нэгж болж, 1.19 хувиар буурав.
Монголын эдийн засгийн чуулган энэ сарын 30-31-нд Төрийн ордонд болно.
Өрхийн хэрэглээ дотоодын нийт бүтээгдэхүүний 58.9 хувийг эзэлж байна.

НИЙГЭМ
2017 оны эхний улирлын байдлаар 13 орны 69 иргэнийг Монгол Улсаас албадан гаргажээ.
АТГ-ын Ажлын хэсэг БСШУСЯ-нд ажиллаж, авлигын эрсдэлийн үнэлгээ хийв.
Г.Дэнзэн нарын таван хүнд холбогдох хэргийг шүүх хурлыг дахин хойшлууллаа.
ОХУ-ын Элчин сайдын яамны зогсоолд тавьсан машин руу буудсан хэрэг гарчээ.
Улсын хэмжээнд 26.2 сая эх мал төллөхөөс 3.6 хувь нь буюу 819.9 мянга нь төлөжээ.

ДЭЛХИЙ
Владимир Путин, Шинзо Абэ нар ирэх сарын сүүлчээр ОХУ-д уулзах тов гарчээ.
Дэлхийн худалдааны байгууллагад Хятадын эсрэг гомдол гаргахаа Сөүл мэдэгдлээ.
Пакистаны Ерөнхий сайд Афганистантай хилийн худалдаагаа сэргээхээр болов.
ОХУ, Энэтхэг 2025 он гэхэд худалдаа эргэлтээ 30 тэрбум ам.долларт хүргэнэ.
Манай гарагийн хамгийн аз жаргалтай ард түмнээр норвегичуудыг нэрлэжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.03.21





4°

-7°

БАГА ЗЭРГИЙН ЦАСТАЙ


ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НУУГУУС ҮНШИНЭ ҮҮ.



8 658 000 1029112 00597

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Технологийн талбар, мөнгөний авдар



Ухаалаг төхөөрөмжөөс хэт хамаатай болсон орчин цагийн дэлхийд видео тоглоомын байлдан дагуулалт хүчээ авч байна. ▶11

Б.Ганбаяр/ЗГМ©

2017.03.21 “Олон улсын ойн өдөр”

МЭНДЧИЛГЭЭ



Өнөөдөр энэ өдрийг дэлхий даяар ойн асуудлаар ярилцах, харилцан ойлгоцохоор “Ой ба энерги” сэдвийн дор тэмдэглэж байна.

Ой бол агаар, ус, хөрсийг хамгаалагч, хүн төрөлхтний эрчим хүчний хэрэгцээг хангаж ирсэн цэнхэр гарагийн маань “ногоон уушги” болсон байгалийн гайхамшигт ертөнц юм.

Монгол Улсын Засгийн газраас ногоон хөгжлийн үзэл баримтлалыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, экосистемийн тулгуур зүйл болсон ойн нөөцийн бодлогыг цоо шинээр авч үзэж байна.

2016 оны Үндэсний ойн тооллогын баримтанд тулгуурлан ойн төлөв байдлыг үнэлэхэд, Монгол орны ой өсөлт удаан, хөгширсөн, нөөцөөр ядмаг, бага ашиглагдсан байгаа нь тогтоогдсон. Иймд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, сайн өсөлттэй, бүтээмж өндөртэй ой модыг бий болгох шаардлага тулгарч байна. Энэ утгаараа Монгол Улсын Их Хурлаас “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ыг баталж, Засгийн газар хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ой, модны салбарын өмнө тулгамдаж буй олон асуудлыг Монгол улсын нийт иргэд бид хамтдаа шийдвэрлэж чадна гэдэгт итгэл төгс байгааг баярын энэ өдөр онцлон тэмдэглэж байна. Энэ үйл хэрэгт Монголын нийт иргэд, ойчид та бүхний оруулах хувь нэмэр, идэвх зүтгэл урьд урьдынхаас илүү чухал, онцгой үүрэгтэй.

Ой, мод бол амьд өв юм. Ойгоо ургуулж, зүй зохистой ашиглаж, хамгаалцгаая.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД



Д.ОЮУНХОРОЛ

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Өмгөөлөгчдийн орлогыг шилэн болгох гарц

Өмгөөлөгч нар өндөр хөлс нэхэх нь зохимжгүй

Б.Гандолгор
@gandolgorZGM

Монголд хамгийн ашигтай мэргэжил өмгөөлөгч болоод байна. Тиймээс ч залуус энэ мэргэжил рүү хошуурах болсон. Тодорхой тогтсон үнэ ханшгүй, өөрсдийнхөө дур зоргоор хохирогчдоос өмгөөллийн хөлс нэхдэг гээд хэлчихэд хилсдэхгүй байх. Уг нь хамгийн шударга, өгөөмөр нинжин сэтгэлтэй хүн бол өмгөөлөгч байх ёстой гэж

үздэг юм билээ. Гэтэл өнөө цагт зөвхөн мөнгөний төлөө л тэд үйлчилж байна уу гэлтэй.

Өмгөөлөгч гэж чухам хэн бэ. Онолын үүднээс тайлбарлавал өмгөөлөгч нь иргэн, хуулийн этгээдэд хууль зүйн мэргэжлийн тусалцаа үзүүлдэг хуульчийг хэлнэ гэж тодорхойлсон байх юм. Монгол Улс 1926 оноос аливаа хэргийг Байцаан шийтгэх тухай хуулиар өмгөөлөгчийг “төлөөнөө заалдагч” гэсэн нэрээр яллагч томилогдсон хэрэгт оролцуулдаг байжээ. Үүнээс хойш 1928 оны тавдугаар сарын 25-нд өмгөөлөгчийн анхны эрх зүйн зохицуулалт болох Шүүн таслах тухай олонд тусламж үзүүлэх бүлгэмийн дүрмийг баталжээ.

▶3

FT

FINANCIAL TIMES

Сербийн мэдээллийн хэрэгсэл дэх Кремлийн оролцоо

Эндрю Бирн
Sputnik 2014 оны эцсээр Сербид нээгдэх үед Белград хотын нам гүм арын гудамжнаа зорчих иргэд доогтой хяламхийх төдий өнгөрдөг байв. Гэтэл хоёрхон жилийн дараа Кремлийн өгөөмөр санхүүжилтэд баярласан Сербийн голлох улстөрчид ОХУ-ын тал баримтлагч мэдээллийн агентлагийн хаалгаар цувах боллоо.

Агентлагийн сараалжин хаалттай цонхны цаана ажиллах орон нутгийн гучаад сэтгүүлчийн бэлтгэсэн цахим материалыг Сербийн 20 гаруй радио станцад үнэгүй нийлүүлдэг. Сербийн сонсогчдод “Оросын дуу хоолой”-г хүргэдэг

тус редакц Москвагаас хараат бус ажилладаг талаар ерөнхий редактор, 64 настай Любинка Милинчик тайлбарлав.

Тус агентлагийн нэр хүнд өргөжсөн нь Балканы эмзэг бүс нутагт тогтворгүй байдал үүсгэж болзошгүйд Европын холбоо түгшиж байна. Балканд худал ташаа мэдээллийн компани өрнүүлж буй ОХУ-ыг сөрөн зогсож, өрнөдийн итгэл үнэмшлийг өндөрт өргөхийн тулд улам ихийг хийхийг Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй саяхан Европын холбооны удирдагчдад уриалсан.

▶9

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
847.99 1.19%	1232.40 0.29%	5935 0.44%	93.310 0.09%	99.940 0.09%	2458.10	355.99	42.93

Улс төр

ЗАСГИЙН ГАЗАР

Төр бүсээ чангалж, хямралыг давна

Гадаад валютын нөөц сүүлийн дөрвөн жилд анх удаа өсөлттэй гарчээ

Б.Даваатогтох
@datoZGM

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат төрийн албан хаагчдын төлөөлөгчидтэй уулзаж, танхимынхаа өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг товч танилцуулав. Тэрбээр төсвийн сахилга батыг сайжруулж, нэгдсэн нэг төсөвтэй болсныг онцоллоо. Өнгөрсөн хугацаанд таван өөр төсөвтэй байсан юм. Үүний хор уршгаар төсвийн сахилга бат алдагдсан тод жишээ бий. Тодруулбал, 2012-2016 онд Архангай, Хөвсгөл аймгийн төвд автозам тавьжээ. Хөвсгөл аймгийн төвд долоон км замыг долоон тэрбум төгрөгөөр тавьсан бол үүнтэй яг адилхан нөхцөл, хэмжээтэй долоон км замыг Архангай аймагт гурав дахин их өртгөөр буюу 21 тэрбум төгрөгөөр тавьсан аж. Мөн Увс аймагт найман тэрбум төгрөгийн өртөг бүхий автозамыг төр, засгийн ямарч шийдвэргүй, гэрээ хэлцэлгүй барьсан байна.

Тэгвэл Засгийн газраас эдийн засгаа сэргээх, төсөвт хэмнэлт хийх, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлогыг шат дараатай хэрэгжүүлж эхэлсэн байна. Үр дүн ч гарчээ. Тодруулбал, 2016 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр 2012 оноос хойш дөрвөн жилийн турш тасалдсан төсвийн орлого анх удаа 504 тэрбум төгрөгөөр давсан байна. Мөн алдагдалтай байсан гадаад худалдаа 1.6 тэрбум ам.долларын ашигтай, гадаад валютын нөөц сүүлийн дөрвөн жилд анх удаа өсөлттэй гарчээ.

Мөн багтаад БНХАУ-ын “Чалко” компанид Монгол Улс удтал төлж ирсэн нүүрсний сунжирсан өрийг энэ сард бүрэн барагдуулж дуусгана гэдгийг



Б.Ганбаяр / ЗГМӨ

тэрбээр тодотгов. Ингэснээр Тавантолгойн ордын Зүүн цанхийн нүүрс долоон жилийн дараа Монгол Улсын мэдэлд эргэн ирж байгаа аж. Өөрөөр хэлбэл, Зүүн цанхиас олборлож борлуулсан нүүрсний ашиг одоо Монгол Улсын төсөвт орно гэсэн үг. Засгийн газрыг байгуулагдаж байх үед Тавантолгойн нүүрсний үнэ 27 ам.доллар байсан юм. Гэвч Засгийн газраас Тавантолгойн ордын нүүрс борлуулах дуудлага худалдааг ил тод, нээлттэй явуулах шийдвэр гаргасан. Үр дүнд нь Монгол Улсын түүхэнд хамгийн өндөр буюу нэг тонн нүүрсээ 72.5 ам.доллараар борлуулж эхэлсэн.

Үүнээс гадна хугацаа төлсөн бондын эргэн төлөлтийн асуудлыг шийдсэн гэдгийг онцоллоо. Энэ талаар тэрбээр “Энэ оны гуравдугаар сард төлөх ёстой 580 сая долларын хугацаа тулсан өрийг Монгол Улс төлж чадах уу, чадахгүй дампуурлаа зарлуулах уу гэсэн ард түмэн

болон олон улсынхны эргэлзээ, тээнэгэлзээ дунд бид анх ажил авсан. Харин өнөөдөр Монгол Улс хугацаа тулсан бондын өргүй болж, 580 сая ам.долларын өрийг бүрэн шийдэж, улмаар жолоо цулбуургүй мэт уруудаж явсан эдийн засагтаа ч, итгэл алдраад явчихсан гадаадын хөрөнгө оруулагчдын өмнө ч ногоон гэрэл асааж чадлаа” гэлээ.

Уулзалтын төгсгөлд тэрбээр төрийн албан хаагчдад хэд хэдэн чиглэлээр үүрэг даалгавар өглөө. Тэрбээр төрийн албаны тансаглал, илүү зардлаас татгалзаж, хэмнэлтийн горимд ажиллах ёстойг сануулав. Өөрөөр хэлбэл, эдийн засгаа сэргээх, эргэлтийн үеийн хамгийн хүндийг үүрэх их ажилд, төр өөрөө бүсээ чангалах, төрийн албаныхан та бид хэмнэх, төрийн тансаглалыг зогсоох оролцоо чухал гэдгийг онцолсон юм.

Хэмнэлтийн хүрээнд төрийн томилолтоор гадаадад болон

дотоодод онгоцоор зорчих хүмүүс энгийн суудалд, хамгийн хямд тийгээр зорчих ёстой гэлээ. Татвар төлөгчдийн хөрөнгөөр, ердийн тийзнээс 2-6 дахин өндөр үнэ төлж бизнес ангилалд тухалж явдаг төрийнхний тансаглалыг өнөөдрөөс тасалбар болгох үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад даалгав.

Ард түмнээ хэрэглээний шинэ сахилга бат, хямгач сэтгэлгээнд суралцахыг уриалав

Мөн төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирлууд байгууллагаа ашигтай ажиллуулж чадахгүй бол чаддаг хүнд нь ажлаа

өгөх ёстойг анхааруулсан юм. Засгийн газар байгуулагдсан даруйдаа төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн захирлуудын цалин, урамшууллыг 30-60 хувь бууруулсан билээ. Тодруулбал, нэг сарын цалин хөлс нь 5-10 сая төгрөг бол 30, 10-30 сая төгрөг бол 50, 30 сая төгрөгөөс дээш бол 60 хувь бууруулсан юм.

Тэрбээр “Ард түмэн маань тунгалаг төрөөр үйлчлүүлж, шударга нийгэмд тайван амьдрахыг хүсэж байна. Энэ хүсэл, хүлээлтийнх нь төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэнэ гэж улстөрчид бид саналыг нь авсан. Төрийн албаныхан та бүхэн тангараг өргөсөн гэдгээ ухамсарлаж, сэтгэл, зүтгэл гаргаж ажиллахыг та бүхнээс хүсэе” гэв. Дашрамд дурдахад, тэрбээр ард түмнээ бүсээ чангалах дэглэмд бус, хэрэглээний шинэ сахилга бат, хямгач сэтгэлгээнд суралцаж, дадахыг уриалсан юм. [ЗГМ]

ЗГМ: тодруулга

Г.Эрдэнэбат: Прокурорын нийгмийн өмнө хүлээсэн үүргийг илүү тодорхой болгоно



Прокурорын хараат бус байдал, хариуцлагыг шинэ шатанд гаргана

Б.Тогтох
ЗГМ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа. Энэ талаар Улсын ерөнхий прокурорын орлогч прокурор Г.Эрдэнэбатаас дараах зүйлийг тодрууллаа.

-Прокурорын тухай хуулийг шинэчилэн найруулахын

давуу тал нь юу вэ?

-Прокурорын тухай хуулийг өөрчлөх гурван төрлийн хэрэгцээ байсан. Нэгдүгээрт, нийгмийн шударга ёсыг прокуроруудаас шаардаж байна. Шударга ёсны төлөө хариуцлагатай, санаачлагатай ажиллах шаардлага бий. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчныхоо хүрээнд санаачлагатай ажиллаж байгаа боловч прокурорууд нийгэмд шударга ёсыг тогтоохын төлөө, гэмт хэрэгтэй тэмцэх, Үндсэн хуулиар хүлээсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд эрх зүйн нарийн зохицуулалт хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, өнөөгийн нийгэм илүү тодорхой зохицуулалттай хуулийг шаардаж байна. Прокурорын өгч байгаа хариу, гаргаж буй шийдвэр болон эрх зүйн орчин ерөнхий

байгаа нь нийгмийн хүлээлтэд хангалалттай хариу болж чадахгүй байгаа юм. Прокурорууд хуулиар илүү тодорхой үүрэг хүлээж, тодорхой ажил хийх ёстой. Өгч буй хариу, гаргаж байгаа шийдвэр зэрэг прокурорын бүхий л үйл ажиллагаа нээлттэй, хараат бус байхаас гадна тодорхой байх нь чухал. Үүний тулд Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд прокурорын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын тогтолцоо, эрх хэмжээний талаар нарийвчилж тусгасан.

Гуравдугаарт, Монгол Улсад эрх зүйн шинэчлэл хийгдэж байна. Прокуроруудын барьж ажилладаг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байна. Үүнийг дагаад прокурорын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын тогтолцоог шинэчлэх шаардлага байгаа юм. Эдгээр гурван төрлийн хэрэгцээнд тулгуурлан уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа.

-Энэ удаагийн өөрчлөлтийн гол агуулга нь юу вэ?

-Хараат бус байдал, хариуцлагын асуудлыг шинэ шатанд гаргахаар холбогдох зүйл, заалт тусгасан. Мөн дээр дурдсан хэрэгцээ шаардлагын дагуу нийгмийн өмнө хүлээсэн үүргийг илүү тодорхой болгоно. [ЗГМ]

эшлэл



гэдэг ямар ч мөнгөнөөс илүү.

Тэр бас босго байх ёстой. Тэгэхээр “та нэг бол мөнгө олох ёстой, эсвэл та тэдэн мянган намын гишүүнийхээ дэмжсэн бичгийг аваад ир” гэж болно доо. Эсвэл сонгогчид ард түмнээс “танай намын энэ хүнийг би дэмжиж байна” гэдэг дэмжлэг аваад ир гэдэг ч юм уу. Энэ бол улс төрийн намын хувьд том шалгуур байх ёстой. Тэгэлгүй ганц мөнгөний шалгуур тавьчих юм бол лангуун дээр намынхаа албан тушаалыг үнийн жагсаалт гаргаад зарчихаж байгаатай адил.

УИХ-ын гишүүн
Л.Болд



-Улсын дээд шүүх Ардчилсан намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хүлээж аваагүй нөхцөлд хуучин дүрмээрээ ажиллана. Дээд шүүхийн шийдвэрийг зөрчөөд дотоод сонгууль явуулах боломжгүй. Сонгуульд оруулахыг хязгаарлахаас эхлээд эрх бий. Ер нь Дээд шүүхийн шийдвэрийг зөрчих эрх хэнд ч байхгүй. Хуучин дүрэм буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа дүрмээр сунгаагаа явуулна. Ардчилсан нам сунгаа явуулж болно гэж заачихсан. Харин Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүдийг Их хурлаасаа байгуулна гээд заасан. Гэхдээ сунгаа явуулж, ялалт байгуулсан гишүүдийг намын Их хуралд танилцуулаад явах боломж бий.

Нийслэлийн Ардчилсан намын дарга
Э.Бат-Үүл

ТОВЧХОН

» АЙЛЧЛАЛ

УИХ-ын дарга М.Энхболд энэ сарын 26-нд Япон улсад айлчлал хийнэ. Айлчлалын хүрээнд Монгол, Японы стратегийн түншлэлийн дараагийн дунд хугацааны хөтөлбөрийг эцэслэн тохирох талаар санал солилцох аж. Мөн Монгол Улсын Засгийн газраас Японы Засгийн газарт хандаж тавьсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг ярилцахаар төлөвлөжээ.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Н.Наранбат тус улсын Ерөнхийлөгч Милош Земанд итгэмжлэх жуух бичгээ барив. Уулзалтын үеэр Элчин сайд хоёр улсын хоорондын уламжлалт найрсаг харилцаа, тал бүрийн хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх, ялангуяа иргэд хоорондын хамтын ажиллагаанд анхаарал хандуулан ажиллахаа илэрхийлэв.

» ТОМИЛОЛТ

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат өнөөдөр Говь-Алтай аймагт ажиллаж байна. Тэрбээр энэ сарын 24-нийг хүртэл Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Ховд аймагт ажиллана. Тэрбээр иргэдтэй уулзаж, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрүүдийг танилцуулах юм байна.

» ТӨСӨЛ

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслөөр зөрчилд хамааруулахаар 600 гаруй нэр төрлийн зөрчлийг томъёолж, үйлдсэн этгээдийг шалган шийдвэрлэж, шийтгэл ногдуулах харицлагч зохицуулах юм.

» ТОО

290

Ажиллагаа. 2012 онд хийсэн судалгаагаар нэг шийдвэр гүйцэтгэгчид жилд дунджаар 250-290 гүйцэтгэх хуудсаар олгогдсон ажиллагаа ногддог аж. Энэ нь холбогдох эрх зүйн актаар тогтоосон ажлын ачааллаас хоёр дахин их байгаа юм. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулжээ.

» НАМУУД

Ардчилсан намын дотоод сонгуульд өрсөлдөхөөр бүртгүүлсэн 565 хүнд нэр дэвшигчийн үнэмлэх гардууллаа. Эдгээр нэр дэвшигчийн 511 нь Үндэсний бодлогын хорооны гишүүнд өрсөлдөхөөр бүртгүүлсэн бол 54 нь нийслэл, аймаг, дүүргийн намын хорооны даргад өрсөлдөх аж. Дотоод сонгуулийн санал хураалт ирэх сарын 2-нд болно.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

**Дэлхийн бусад орны
адил Монголын
өмгөөлөгч нар
НӨАТ төлдөг байх
ёстой**

Ингэснээр өмгөөллийн үйл ажиллагааг зохицуулах хэд хэдэн дүрэм, хууль тогтоомжтой болсон байна. Харин өдгөө хууль зүйн фирм, өмгөөллийн төрийн бус байгууллагууд олширчээ. Энэ хэрээр өмгөөлөгчдийн тоо ч жил бүр нэмэгдсээр байна. Холбогдох байгууллагаас авсан мэдээллээр манай улсад 2124 өмгөөлөгч үйлчилдэг аж.

Гэхдээ өмгөөлөгчийн яс чанар нэлээд муудсан талаар мэргэжилтнэгт нөхөд нь хэлж байв. Уг нь хүний эрхийг хамгаалж, өмгөөллийн үйлчилгээг сайн үзүүлэх үүрэгтэй хүмүүсийн зарим нь ажилдаа нэр төдий ханддаг аж. Өөрөөр хэлбэл, хохирогчоос зөвхөн мөнгө аваад байдгаас эрхийг нь хамгаалах, өмгөөлөх үйлчилгээ нь тун хангалтгүй байдаг талаар иргэд ч холбогдох байгууллагад цөөнгүй гомдол гаргадаг юм билээ. Мэргэжил ёс зүйн хороогоор арга хэмжээ авахуулсан хуульч мэргэжилтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн олонх нь мөнгө авчихаад ямар ч үйлчилгээ үзүүлэхгүй “луйвардсан” юм шиг алга болдог аж. Үүнийг эрхзүйч, хуульч хүмүүс өмгөөллийн үйлчилгээ рүү хүч түрэн орж ирснээс болсон гэж тайлбарлах хүн ч байгаа юм. Өмгөөлөгч бэлтгэх, өмгөөлөгчийн ухамсар, соёл, сэтгэлгээг гүнзгий суулгах бодлого өнөөдөр байхгүйтэй адил. Өмгөөлөгчийн үнэмлэхтэй, мэргэжлийн дипломтой бол сайн гэж харагдаж, үйлчлүүлэгчид итгэл төрүүлж, сайн сэнхрүүддэг ч ажлаа хангалттай хийж чадаагүй гэсэн шүүмжлэлийн мэргэжлийн байгууллагынхан хэлж байв.

Гэтэл үнэн хэрэг дээрээ өмгөөлөгчид ажил мэргэжилдээ сэтгэлээ өгч, хүн чанар гаргаж, үйлчлүүлэгчдийнхээ зовлон жаргалыг ойлгож, өмгөөлж байна уу гэвэл үгүй аж. Ер нь өмгөөлөгчдөө сургалтаас эхлээд ёс суртахуун, ухамсрын үнэлэмж, суулгах цогц арга хэмжээнүүд хэрэгтэй болжээ.

Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ

Улаанбаатар хот

№.....

сарын өдөр

Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ" (цаашид "гэрээ" гэх) гэрээг нэг
 дэх салбарын Улсын өмгөөлөгч (цаашид
 "ас иргэн" (цаашид "Үйлчлүүлэгч",
 дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож

Хий нөхцөл

члүүлэгчид хууль тогтоомжийг нийцсэн
 нөхцөл журам, талуудын эрх, үүрэг,
 а. баасан ажил үүргийг
 хуулийн

Б.Ганбаяр / ЗГМ©

Өмгөөлөгчдийн орлогыг шилэн болгох гарц

**ӨМГӨӨЛӨГЧ НАР
ӨНДӨР ХӨЛС НЭХЭХ НЬ
ЗОХИСГУЙ**

Гавьяат хуульч Ж.Яринпил “Хууль зөрчсөн хэн нэгэн этгээдийн буруугаас болж, эрх нь хөнгөлдсөн хүнийг өмгөөлөгч хүн хамгаалах ёстой. Гэтэл мэдлэг, чадвар дутмаг өмгөөлөгч нар олширвол хохирогчийн эрхийг хамгаалж чадахгүй шүү дээ. Иймээс өмгөөлөгч хүн мэдлэг, чадвар, туршлага дадлага, эр зоригтой байх хэрэгтэй. Нийгэмд хамгийн үнэтэй зүйл бол хүний эрх. Үнэ цэнтэй хүний эрхийг хамгаалах чадварыг өмгөөлөгч төгс төгөлдөр эзэмшсэн байх үүрэгтэй. Өмгөөлсөн хэргийнхээ эцсийн үр дүнг муугүй үзүүлэлтэй гаргахын тулд хүн өөрийгөө дайчилж ажиллах хэрэгтэй. Өмгөөлөгч хүн хэт өндөр хөлс нэхэх нь буруу. Хүний зовлон дээр дөрөөлж, хэдэн халтар төгрөгөнр шунаж болохгүй” хэмээсэн удаатай.

Гэвч сүүлийн үеийн өмгөөлөгч нар мөнгөний төлөө ажилладаг болсон нь нууц биш. Хохирогчоос хэтэрхий их мөнгө нэхэж авсан өмгөөллийн орлого

нь өөрсдийнх нь халаасанд үлддэг. Улсад татвар татаас барагтай бол төлдөггүй. Тэгвэл татварын хуульд өөрчлөлт оруулж НӨАТ төлдөг болсон нь өмгөөлөгч нарын эгдүүдийнхүргэх боллоо. Тодруулбал, 2016 оны нэгдүгээр сарын 1-нээс өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөөг НӨАТ-д хамааруулдаг болов. Өмгөөлөгч хүн олсон орлогоосоо татвар төлөх нь угтаа хууль ёсны зүйл баймаар. Гэвч Монголын өмгөөлөгчид НӨАТ төлөх үүргээ дарамт гэж хүлээж авах болсон байна. Тэдний төлөөлөл “Өмгөөлөгчийн мэргэжлийн ажил буюу хүний эрх, эрх чөлөөний төлөөх тэмцэл хэдэн арван сар, жилээр үргэлжилдэг. Засаг төрийн эрх мэдэлтэн, албан тушаалтнуудыг хууль бие-лүүлэхийг шаарддаг. Харин тэд татварын системээр дамжуулан өмгөөллийн үйл ажиллагааны нууцад нэвтрэх боломжтой болсон” хэмээн гомдоллох юм.

**АНУ, ХЯТАДЫН
ӨМГӨӨЛӨГЧ НАР ӨНДӨР
ТАТВАР ТӨЛДӨГ**

Монгол Улс зөвхөн өмгөөлөгч-

дөсөөт татвар авахаар болсон юм биш. Дэлхийн олон орны өмгөөлөгчид орлогоосоо татвар төлдөг. Жишээ нь, АНУ-ын өмгөөлөгч нар жилд дунджаар 101.367 ам.долларын цалин авдаг байна. Татварын хэмжээ нь муж улсаасаа хамаараад өөр өөр байдаг аж. Alaska, Nevada, Washington зэрэг хот, мужид орлогын татвар төлдөггүй бол бусад нь орлогынхоо 1-13.3 хувийг төлдөг байна. Харин Нью-Йоркийн харьцангуй өндөр, өмгөөлөгч нарын гь орлогын татвар 4-8.82 хувь байдаг аж. Ганц бие хуульч, өмгөөлөгчид жилийн 89 мянгаас өндөр орлого олвол 28 хувийн татвар төлдөг бөгөөд үүн дээр суурь хураамж болгон 18.193,75 ам.доллар авдаг байна. Гэр бүлтэй болсон өмгөөлөгчид суурь хураамж 10162 ам.доллар дээр нэмж 25 хувийн татвар төлөх үүрэг хүлээнэ.

Тэгвэл Хятадад өмгөөлөгч нар
их орлого олох тусмаа төдий
хэмжээний өндөр татвар төлдөг
байна. Сард 80 мянган юанийн
орлого олвол үүнийхээ 45 хувийг
орлогын албан татварт өгдөг гэх

МЭТ олон орны жишээг дурдвал дундаршгүй.

**Өмгөөлөгч нар НӨАТ
төлдөг болох нь
шударга ёсонд
нийцнэ**

Харин ОХУ-ын хувьд бол өөр. Өмгөөлөгч нараас татвар авахыг чухалчилж үздэггүй юм билээ. Улс орнуудын өмгөөлөгч нар ийн өндөр татвар төлж байхад Монголын өмгөөлөгчид бүх нийтээрээ төлдөг НӨАТ-аас бултах аргагүй. Бүр өмгөөлөгчдөөс хамгийн өндөр татвар авах нь зөв юм. Өнгөрсөн жил үлдээх хуульчид өөрсдийнхөө халаасанд шингээж ирсэн өмгөөлөгчид одоо татвар төлөх цаг нь болсон. Хэдий болтол манай улс өмгөөлөгч, хуульч нарыг дур зоргоор нь эрхлүүлэх вэ. Аливаа зүйлд дөрмөж журам, тэгш эрх байх ёстой. Өмгөөлөгч нар НӨАТ төлдөг болох нь шударга ёсонд

нийцнэ. Харин үйлчлүүлэгчдээс татвар авах нь зохисгүй юм. Өмгөөлөгч нарын хэлж буйгаар бол НӨАТ-ыг үйлчлүүлэгч төлөх үүрэгтэй ч бид орлогоосоо илүүлэх нь гэсэн тайлбар хийж байна. Уг нь ядарсан үйлчлүүлэгч биш өмгөөлөгч НӨАТ төлөх нь хамгийн зөв зохицуулалт байх учиртай. Түүнээс биш үйлчлүүлэгч төлөх нь жинхэнэ татварын дарамт болох бус үү.

Манай улс дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах гэж байгааг бид бусад орны жишгээр өмгөөлөгчдөөс орлогын албан татвар авах нь туйлын зөв зохицуулалт. Гэтэл гэд НӨАТ төлдөг болсон гээд өмгөөлөгчид хөлөө нэмбэл яах вэ. Үүнд л хатуу хяналт тавих шаардлага тулгарч байх. Манай улсад өмгөөлөгчдийн орлогын талаар тодорхой тоймтой судалгаа байдаггүй. Хэн гэдэг өмгөөлөгч жилд хэчнээн төгрөг олж, нэг үйлчилүүлэгчээ хэдэн төгрөгөөр өмгөөлдөг тухай мэдээлэл олон нийтэд хаалттай байдаг. Тиймээс тэдний орлогыг ч гэсэн шилэн болгож байж эрүүл нийгэм бүрэлдэн тогтох учиртай. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...

**ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ
2017 ОНЫ II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА.
ЗАХИАЛГЫН ҮНЭ: 30,000₮**

УЛИРАЛД

64 ДУГААР



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, И-мэйл: info@zasag.cc
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: ubinfo.mn

Олон улсын ойн өдөрт

Энергийн цуурай

-Уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний аюулгүй байдлын хувьд модны эрчим хүч ач холбогдол болон алсын харааны шинэ шатанд гарлаа-

Хүн төрөлхтний эрчим хүчний анхны эх үүсвэр нь ердөө л мод байв. Олон мянган жилийн турш дэлхийн өнцөг булан бүрт хүмүүсийн дулаацах, амьд үлдэх, хооллох гээд гол эх үүсвэр, гэрэл гэгээ нь мод болж байлаа. Харин эл байр сууриа XIX зууны дунд үеэс олборлох түлшинд алдсан. Гэвч хөгжингүй орнууд нас бие гүйцсэн моддыг дахин тоож эхэлсэн нь өдгөө дэлхий дахинд цуурайтаж эхэллээ.

Түлшний мод нь ойн маш чухал бүтээгдэхүүн. Дэлхийн түлшний мод бэлтгэлийн хэмжээ нь үйлдвэрлэлийн зориулалтаас давсан үзүүлэлттэй байна. Түлшний мод болон модны нүүрс үйлдвэрлэл нь шилжилтийн үеийн эдийн засагтай улс орнууд хийгээд хөгжиж буй орнуудад модлог биомассын зонхилох хэрэглээ болж хувирав.


Харин хөгжингүй орнууд модыг цэвэр эрчим хүчний нэг хэмээн үзэн, төрийн бодлогоор дэмжиж эхэллээ. Сонирхолтой нь, сэргээгдэх эрчим хүчний салбарт мод, мод боловсруулж бэлтгэсэн түлшний хэрэглээ жин дарах болов. Хойд Америк, Европын орнуудын цэвэр эрчим хүчинд өдгөө мод моодонд орж байна. АНУ-д л гэхэд био түлш ногоон эрчим хүчний 25 хувийг эзэлдэг нь усан цахилгаан станцын орон зайнаас давсан үзүүлэлт юм.

МОД ТӨВТЭЙ ЭРЧИМ ХҮЧ

Түүхэн талаасаа мод бол зөвхөн ойгоор баялаг улс орон, бүс нутгийн эрчим хүчний хэрэглээ байв. Харин технологийн дэвшил, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих бодлогын ачаар хэрэглээ нь улам тэлэх боллоо. Өнөөдөр уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний аюулгүй байдлын хувьд модны эрчим хүч ач холбогдол болон алсын харааны шинэ шатанд гарав. Модны эрчим хүч дор дурдсан нөхцөлийг хангасан үед цаг уурын хувьд саармаг нөлөөтэй, нийгмийн хувьд сэргээгдэх эрчим хүчний боломжит эх үүсвэр гэж тооцогддог. Тухайлж хэлбэл, тогтвортой менежменттэй нөөцөөс бэлтгэгдсэн мод. Зохих түлшний үзүүлэлтийг хангасан (усны агууламж, илчлэг, хэлбэр гэх мэт). Ашигтай шаталттай буюу доторх болон гаднах ялгаралтыг бууруулсан. Модны цуултыг дахин ашиглах, тохиромжтой материал ашиглах, эрчим хүчийг хэрэглэхийн өмнө дахин ашиглах ба дахин боловсруулах зэрэг юм.

АНУ-д ногоон эрчим хүчний хэрэглээ усан цахилгаан станцын хэрэглээнээс давлаа

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуй (FAO)-н байгууллагаас гаргасан тайлангаар модон бүтээгдэхүүний худалдаа жил ирэх бүр аажмаар саарсаар. Харин түлшний зориулалтаар хэрэглэж буй модны худалдаа 2015 онд зургаан жил дараалан өссөн үзүүлэлттэй. Уг өсөлтөд Азийн хөгжиж буй эдийн засгуудын өсөлт, Хойд Америкийн орон сууцны зах зээлийн сэргэлт, цаашлаад био эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилт нөлөөлжээ. Мод нь дэлхийн хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний гуравны нэгийг эзэлж байгаа нь цэнхэр гарагийн цэвэр эрчим хүч мод төвтэйг харуулж буй



юм. Түлшний модыг өнөөдөр шууд болон шууд бусаар бэлтгэж эхэллээ. Нэг хэсэг нь ойгоос шууд авч түлдэг. Нөгөө хэсэг нь боловсруулсан болон үйлдвэрийн хаягдал модыг био түлш зэрэг боловсруулсан бүтээгдэхүүн болгон хэрэглэж байна. Ийм түлш нийт хэрэглээний 58 хувийг бүрдүүлдэг. Европын 56 орноос гадна АНУ, Канад, ОХУ, Хамтын нөхөрлөлийн орнуудад боловсруулсан түлшийг өргөн хэрэглэх болжээ. Харин нийт хэрэглээний 33 хувь нь ойгоос шууд бүрдэж байгаа бол дөрөв орчим хувийг тарьж ургуулсан, 5.4 хувийг зориулалт нь тодорхойгүй хаягдал бүрдүүлж байна.

Орчин үед модны эрчим хүч нь ойн нөөц ихтэй, нүүрс түлдэг цахилгаан станцтай мөн модлог биомассыг түлшинд ашигладаг бүс нутагт хамгийн түрүүнд эдийн засгийн хувьд ашигтай байгаа юм. Хүн амын суурьшлын бүст харьцангуй ойр орших ойн нөөц ихтэй газар боломжийн тээврийн зардлаар дан биомассын эрчим хүчийг боловсруулах, эсвэл этанол үйлдвэрлэх байгууламж бий болгох боломжийг санал болгож яагаад болохгүй гэж.

ЭРГЭЛЗЭЭ

АНУ-ын Хойд Каролина муж улсад царс мод 20 метр өндөр ургаж, самраа өгөх хүртэл хагас зууныг элээнэ. Харин ингэж ургасан царс модыг Европын цахилгаан станцуудад түлш болгон ашиглахад хэдхэн секунд л зарцуулдаг. Аварга том төхөөрөмжийн тусламжтай био түлш болж, Атлантын далайг гатлан Их Британид очсон царс мод тус улсын цахилгааны хэрэглээний 10 хувийг хангадаг.

Атлантын хоёр эргийн хооронд био түлшний худалдаа ийнхүү тэлэх болсон нь эрдэмтэд, бодлого боловсруулагчид, бизнесийнхэн мод бол нүүрстөрөгчийн давхар ислийг хязгаарлах стратегийн түлш гэдгийг ойлгосны илрэл. Мод бол нүүрс, байгалийн хийтэй адилтгах аргагүй ногоон эрчим хүч. Засгийн газрууд мод бол нүүрстөрөгчгүй цэвэр түлш гэж үзэн, татвар, худалдаа, байгаль орчинтой холбоотой хууль журмын хөнгөлөлт үзүүлж эхлэв.

Угаас байгаль хамгаалагчдын маргааны халуун сэдэв. Улс

дамнасан хууль бус мод тээвэрлэлтийг өөхшүүлж, уур амьсгалын хамгаалагч гэгдэх ойн биологийн олон янз байдлыг үгүй болгох эх үндэс гэж үздэг нь ч бий. Гэхдээ нөгөө талаар ойг тогтвортой ашиглах замаар модны биомассыг нэмэгдүүлэх нь нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна гэсэн эерэг байр

суурь баримтлагчид хавьгүй олон байна.

ДЭМЖЛЭГ

Европчууд 2020 он гэхэд эрчим хүчний эх үүсвэрийнхээ 20 хувийг ногоон болгох зорилтын тулах баганаар модыг сонгов. Их Британи, Бельги, Дани болон Голланд зэрэг улс

био түлшний зориулалттай цахилгаан станц барьж, нүүрсний цахилгаан станцаа модных болгон өөрчилж байна. Ялангуяа Их Британид модыг сэргээгдэх эрчим хүчний гол өрсөлдөгч хэмээн өргөмжлөв. Тус улсын Хойд Йоркширт байрлах био түлшний хамгийн том станцын хүчин чадал 4000 мегаватт.

Тэгвэл АНУ-ын зүүн өмнөд хэсгээс гарч буй модны экспорт 2016 онд 6.5 сая гаруй метр тонн байсныг холбогдох байгууллага нь тэмдэглэжээ. Энэ тоо 2021 он гэхэд есөн сая метр тонн болно гэсэн хүлээлттэй байна. Онцлох учиртай бас нэг зүйл гэвэл, мод нь яаралтай үед ашиглах нөөц түлшний үүрэг гүйцэтгэдэг. Нийгэм, эдийн засгийн аль ч түвшинд эдийн засгийн хүндрэл, байгалийн гамшиг, хурцадмал нөхцөл байдал, олборлох түлшний нийлүүлэлт хомстох үед түвэггүй орлуулах эрчим хүч бол мод.

Өнөөдөр дэлхийн хаана ч био түлшийг дэмжих нь бодлого боловсруулагчдын анхааралд багтжээ. Япон, Өмнөд Солонгос сэргээгдэх эрчим хүчний квотоо хангахын тулд био түлшийг бодлогоор дэмжиж эхлэв. Энэ нь пеллетийн борлуулалт тэлэхэд нөлөөлж байгаа гэж шинжээчид үзжээ. Тэрчлэн өнгөрсөн оны сүүлчээр Европын комисс модон түлшний талаар баримтлах бодлогодоо бага зэргийн өөрчлөлт оруулж, хэрэгжих хугацааг нь 2030 он хүртэл сунгасан байна. Бодлогын түвшний эдгээр алхам нь дэлхийн хуурай газрын 31 хувийг эзлэх ойг ногоон эрчим хүчний эх үүсвэр мөн, эсэхээр өрнөж буй маргаанд цэг тавих биз ээ.


Тэгвэл Монгол Улс ой, модны эрчим хүчинд холбогдох ямар асуудлуудыг судлах хэрэгтэй



БОАЖА-ны Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Тунгалаг

вэ? Мэдээж ахуйн эрчим хүчний хэрэгцээнд зориулагдсан түлээний мод бэлтгэх үйл ажиллагааг тогтворжуулж нэмэгдүүлэх асуудал багтана. Мөн хоол хийх болон халаалтын өндөр технологийн хийгээр ажилладаг төхөөрөмжийг ашиглах. Хот суурин газрын бохирдлыг бууруулахын тулд унасан модыг эрчим хүчний хямд, агаар бохирдуулагч эрчим хүчний бусад эх үүсвэрийн оронд ашиглах. Модны хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс аймаг сумын мод түлдэг аж үйлдвэрийн бойлерыг дэмжих. Өндөр чанарын, баталгаажсан нүүрс, түлшний мод үйлдвэрлэх орон нутгийн иргэд, хувийн хэвшлийг дэмжих. Модонд суурилсан эрчим хүч болон дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг асуудал нэн тэргүүнд хөндөгдөх учиртай.

Ой бол байгалийн гоо үзэсгэлэн бүрэлдсэн гайхамшигт ертөнц төдийгүй агаар, ус, хөрсийг хамгаалагч нь. Сая гаруй жилийн тэртээгээс хүн төрөлхтний эрчим хүчний хэрэглээг хангаж ирсэн цэнхэр гарагийн ногоон “уушги” бол эрин үеийн түлшний эх булаг. Тиймээс ч олборлох түлшний мөчлөгт төгсгөл тавьж, ирээдүйдээ энэ сэргээгдэх баялгаа хадгалахын тулд дэлхий ойн хэлмэрчид ногоон энергийн цуурайг, тэр дундаа өнөөдрийн тэмдэглэлт “Олон улсын ойн өдөр”-өөр түгээж байна.



Загвар

Ирээдүй рүү буцсан нь

Эмэгтэйлэг гэхээс
илүү зоригтой,
эршүүд хувцаслалт
зонхилно

Г.Сайнзаяа
@sainzayaZGM

“What goes around comes back around” гэдэг үгээр кармаг илэрхийлдэг. Энэ тохиолдолд манайхаар “Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр” гэсэн утга илэрхийлнэ. Харин загварын ертөнцөд үүнийг “Моод эргэдэг” гэсэн утгаар ашиглах бөгөөд энэ нь ч нөхцөл байдалд яг цав тохирдог. 1990-ээд оны загварууд эрчээ авч, загасны хээтэй торон оймсыг л гэхэд энэ зун тав алхаад тааралдах магадлалтай трэндээр нэрлээд буй. Загасан триконы гарал үүслийг сөхвөл 1908 онд Америкт үүссэн байдаг. Түүнээс хойш 1920, 1970, 1990 онд моодонд орж, гарсаар эргэн ирлээ. Ээжийн тань өмсдөг байсан гэдэс гарсан богино цамц, чокер зүүлт, бандана, Dr.Martens-ийн гутал байгаа бол нар “үзүүлэх” цаг нь болжээ. Ингээд “The Trend Spot-ter” сайтын хүргэснээр 1990-ээд оны загварыг хэрхэн 2017 онд



амилуулахыг танилцуулж байна.

90-ЭЭД ОНЫ ТУХАЙД

90-ээд оны загварыг залуучууд тодорхойлж, гранж буюу рок, минималист хэв маяг зонхилж байв. Ерөнхийд нь харахад гудамжны, гэсэн хэрнээ дур булаам сурагч охиныг санагдуулам гэж болохоор. Marc Jacobs, Alexander McQueen тэргүүтэй загварын топууд боломж алдалгүй гранж стилийн коллекцууд гаргаж, Кэйт Мосс шиг төрхтэй загвар өмсөгчид бусдыгаа хошуучилж байжээ. Кэйт Мосс тухайн үед “Heroin Chic” буюу хэт туранхай, доод зовхиндоо хөхөлбөр туяатай, зуйван

царайтай, цайвар арьстай охидын албан ёсны төлөөлөл байсан юм. Загвар зохион бүтээгчид Клаудиа Шиффер, Синди Кроуфорд гэх мэт эрүүл төрхтэй загвар өмсөгчдөөс тэс өөр дүр төрх сурталчилж, нэлээд шүүмжлэл хүртсэн. Мөн тухайн үед эмэгтэйлэг гэхээс илүү зоригтой, эршүүд оршихуй загварын ертөнцийг дүүргэжээ.

ГУТАЛ

90-ээд онд эрчээ авсан гранж хөдөлгөөний нөлөөллөөр цэргийн, хүнд гутал гол хандлага болсон. Ийм гутал нарийн мөртэй, нимгэн, сул даашинзаас эхлээд цэцэгтэй, шоотой цамц,

сэмэрхий жийнс гээд ямар ч төрлийн хувцастай зохицдог. Нөгөө талдаа минималист хэв маягийг эрхэмлэгчид эвтэйхэн, энгийн сандаалыг сонгодог. Энэ хоёр гутлаараа алдартай Dr.Martens, Birkenstocks хоёул одоо ч эрэлттэй байна. 90-ээд оны бусад халуухан гутлаас нэрлэвэл Converse-ийн Chuck Taylor, Manolo Blahnik-ийн Mary Jane загварыг дурдаж болно.

ЭРГЭН ИРСЭН НЬ

Загвар зохион бүтээгчид, брэндүүд, нэр алдартнууд тэртээх 20 жилийн өмнөх хэв маягийг сүүлийн үед идэвхтэй сурталчилж байна. Ингэхдээ,

орчин үеийн хэв маягтай хослуулан “амь оруулах” болжээ. Кендалл Женнер, Жижи Хадид, Рианна зэрэг одууд чокер, богино цамцыг орчин үеийн загвартай хослуулахдаа гаргууд. Чокертой хамт “эргээд ирсэн” трэндүүдэд цагариган эзэмэг, бараан өнгийн уруулын будаг, сэмэрхий жийнс, цэргийн гутал, богино болон урт ханцуйтай цамцны гадуур палаж өмсөх зэрэг ч багтсан.

АМИЛУУЛАХ НЬ

90-ээд оны загварын чиг хандлагыг эргэн авчрахын тулд зохимжтой байлгхааар ажиллах хэрэгтэй. Тухайн үеийн хувцаслалтыг яг дуурайхаас илүү

сайжруулж, дахин давтагдашгүй байх нь чухал. Түүнээс биш бүхэлдээ цаг хугацаагаар аялсан мэт байвал болхи харагдаж мэднэ. Тэртэй тэргүй загвараас шигшигдсэн нь л эргэн ирдэг хуультай шүү дээ. Жишээлбэл, чокер, кроп тоныг баригчид өмд, өсгийтэй гуталтай хамт өмсөж болно. Шинэхэн авсан даашинзаа өмсөөд, үсээ таллаж боогоод дотуур нь цамц өмсөж болно. Хамгийн гол нь хувцаслалт биш “хэн юу гэх нь хамаагүй” гэсэн хандлагыг нь хуулбарлаарай. Харин илүү гранж байхыг хүсвэл сүүлийн үеийн даруу, энгийн байдалтай хослуулан зөөллөх хэрэгтэй. [3ГМ]

Миний шүүгээг авраач

Г.Сайнаа
ЗГМ

Хувцас байгальд шингэх нь удаан. Ялангуяа хөвөн даавуун биш, нийлэг материалтай бол хаях гэж яаралтгүй. Нейлонон хувцас 30-40, арьсан гутал 25-40 жилийн дараа байгальд шингэдэг. Монголчууд бид хуучин хувцсаа хүнд өгөхдөө тийм ч таатай ханддаггүй. Өмсөх боломжгүй болтол нь хайчилж, эсвэл шатааж хаядаг. Хаях шалтгаан нь гарын таван хуруунд ч багтана. Нэгдүгээрт, жин нэмж,



багтахаас нэгэнт өнгөрсөн. Хоёрдугаарт, нэг хэсэгтээ толбо болсон. Гуравдугаарт, загвар нь дэндүү хуучирсан. Дөрөвдүгээрт, уйдсан. Гэвч энэ бүх шалтгааныг үгүйсгэж, хувцсандаа дахин нэг “боломж” олгох бололцоо бидэнд бий. Таардаггүй бол өөрчлөөд, толботой бол тэр хэсгийг нь тайраад, загвар нь хуучирсан ч хэдхэн эсгүүр, оёо хийгээд л асуудлыг шийдчихэж болох билээ. Энэ удаад бид сүүлийн хоёр жил гол трэндийн жагсаалтаас буухгүй байгаа кроп топ буюу богино цамц хэрхэн хийхийг зурагт харууллаа. [3ГМ]

Этгээд бас дэгжин халаад

Гэрийн халаадтайгаа гараад ирвэ үү гэмээр хүн тааралдвал та битгий гайхаарай. Өнгөрсөн зун анх үзэгдэж, энэ зунаас гудамжны хэв загварт хүч түрэн орж ирсэн моод бол халаад. Парист болж буй загварын долоо хоног үүнийг баталлаа. Японы кимоноогоос санаа авсан торгон материалтай, урт халаадыг жийнс, цамцны гадуур өмсөвөл илүү загварлаг, этгээд харагдах болно. Хэрэв та бүр ч этгээд харагдах зүрх зоригтой бол ноосон, гялгар, томдсон загвартай халаад сонгоорой. [3ГМ]





UBshop.mn

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

- 1** Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна **Утас: 96481125, 99087992**
- 2** Автомашинны хагарч цуурсан шил наагч зарна. Хүргэлттэй. Үнэ: 35000 төгрөг **Утас: 99679962**
- 3** Шинэ дугуйнууд зарна. Үнэ: 100.000 төгрөг **Утас: 88006734**
- 4** Agiom шинэ дугуйнууд зарна **Утас:99101688 /Үнэ тохирно/**
- 5** 2009 оны "FX35" хямд зарна. Үнэ: 25 сая төгрөг **Утас: 99111468**
- 6** "G500" зарна 2004-2012. Дотор гаднагүй он залуу болгосон машин оролцуулна. **Утас: 99993434**
- 7** 2003 оны 2012 орж ирсэн сувдан цагаан өнгөтэй, beams-2.0 мотортой, ухрах камертай "Grand mark 2" яаралтай зарна.Үнэ 5 сая төгрөг. **Утас: 96651794**
- 8** 2009 оны "HUMMER H2" зарна. **Утас: 91777877**
- 9** 2008 оны "LX570" зарна. Үнэ: 60 сая төгрөг **Утас: 99111468**
- 10** "Full option A8" зарна. **Утас: 99995108**

КОМПЬЮТЕР БА ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

- 1** Гэр болон оффиссын сүлжээ хүрдэггүй газарт сүлжээ дахин дамжуулагч суурилуулна. Угсралт тохиргоо үнэгүй. **Утас: 75752020**
- 2** Black iPad mini Wi Fi 64GB багтаамжтай. Үнэ: 400.000 төгрөг **Утас: 88998138**
- 3** Ipad-1 wifi 16gb зарна. **Утас: 99002508**
- 4** Төмөр гадаргуутай 2TB багтаамжтай зөөврийн hard диск зарна. **Утас: 98886655**
- 5** "Sony Vaio core i5" notebook хямд зарна. Үнэ:500.000 төгрөг **Утас:88102740**
- 6** Sony 15.6 Core I7 560-d зарна. model VPCF133FX Intel(R) Core(TM)i7 Q740 1.70 ghz Ram 4g hhd 500gb Display 15.6 inch numlock **Утас: 88771767**
- 7** “Kory notebook shop” бүх төрлийн used нөтбүүк, таблет худалдаалж байна. Үнийн хувьд хамгийн хямд, өргөн сонголттой. Өдөр бүр 11.00-20.00 цагийн хооронд ажиллана. **Утас: 89997986**

ҮЛ ХӨДЛӨХ

- 1** Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна. 2011 онд ашиглалтанд орсон төмөр бетон суурь, төмөр бөс бетон, 38-ийн дан тоосго, гадна талд хөөсөөр дулаалсан 200м2, 2давхар, машины гражтай, 380в худагийн ус гарсан цэвэр устай, халуун устай, цэвэр бохироо бүрэн шийдсэн өвөл зуны дулаахан чанартай сайн барьсан. - Нийт 6 өрөө, гал тогоо, зочны өрөө, 2 ариун цэврийн өрөөтэй, гал тогоо 00-д халуун устай, вакум цонх, паркетин шалтай дотор интерьер засал сайн. **Утас: 99289768**
- 2** 10-р хороололд Сувилахуйн сургуулийн хойно 47м.кв хоёр өрөө байр зарна. **Утас: 88192130**
- 3** Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна. **Утас: 99466494**
- 4** -Хүүхдийн Паркийн замын урд зам дагуу төвийн шугамд холбогдох боломжтой 300м2. -22-н товчоо тойргийн хажууд зам дагуу Iга 380 тогтой блокон хашаатай газар. -Хонхорт зам дагуу 9200м2 төвийн шугамд холбогдох боломжтой, худалдааны төв, шатхуун түүхээгүүр, аж ахуй, агуулах, хөнгөн үйлдвэр зориулалтаар ашиглах боломжтой газар. -Эмээлтэд 5га газар. **Утас: 99289768**
- 5** Сансарын тунелд 1 давхарын гал тогоо тусдаа 3 өрөө байр зарна. **Утас: 99760217, 99101271**

НОМ, ХЭВЛЭЛ

- 1** Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна. **Утас: 99144154**
- 2** Хуучин номнууд зарна. **Утас: 94640105**
- 3** Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна. **Утас 99153637**
- 4** Ээж ба хүүхэд ном зарна. **Утас: 99089401**
- 5** Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна. **Утас: 99625921**
- 6** Official guide of TOEFL TEST 4th edition. Албан ёсны TOEFL тест гаргадаг газраас уг шалгалтанд бэлтгэгчдэд зориулан гаргасан GUIDE book-ийн хамгийн сүүлийн хэвлэл. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ. **Утас: 99674312**
- 7** Монголын залуучуудад хүн төрөлхтний хөгжлийн их алхаатай хөл нийлүүлэхийн зэрэгцээ өөрийн үндэсний зан заншил, ухамсар, ёс суртахууныхаа үнэт зүйлийг гээлгүй зөв хослуулан авч явахыг зөв ухамсарлан ойлгуулах энгийн хялбараар илэрхийлж чадсан “Монгол хүний хөгжил төлөвшилийн ДЭЭД УХААН” ном уншигчдын гар дээр очиж байна. **Утас: 98111029**
- 8** Өсвөр насныхны дээдэлж мөрдөх 7 зуршил ном зарна.

ЦАХИЛГААН БАРАА

- 1** Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар унтарна. Тэжээл: 2 ААА батарей (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (C) **Утас: 88512938, 96012938**
- 2** Модерн загварын ханын цаг (45-55cm) худалдана. **Утас: 96012938 , 88512938**
- 3** USB гагнуурын алх. Эгшин зуур хална, хөрнө. 480 C градус хүртэл хална.



Утас: 96012938

ХУДАЛДАНА

ПЯНЗ ХУДАЛДАНА. МОНГОЛ, ОРОС, БУСАД.

УТАС: 95777773

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.



Спорт

Кисеносатог хэн зогсоох вэ

**Аваргууд тааруухан
яваа ч өөр нэг монгол
бөх Кисеносатог шил
даран нэхсээр**

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Мэргэжлийн сүмогийн Харү башё замынхаа талаас өнгөрлөө. Дөрвөн ёкосуна нэг дор барилдах буй түүхэн башё учир харвын тэмцээнээс хүн бүр ширүүн өрсөлдөөн хүлээж байгаа. Мөн 2000 оноос хойш анх удаа аварга цол хүртсэн япон бөх болох Кинсеносато хэрхэн барилдах нь хүн бүрийн анхаарлын төвд.

Өмнөх тэмцээнд манай аваргууд бүртэл гэмтлээс болоод олигтой барилдаж чадаагүй. Энэ зэвсэврээр Кисеносато шургалж, сүмогийн дээд цолд хүрч амжсан. Харин энэ удаа даварсан нөхрийн хандыг дарж, ёкозүна цолны босго өндөр гэдгийг мэдрүүлэх нь Монголын гурван аваргын хувьд чухал байсан нь мэдээж. Гэвч шинэ аварга аатай, бярттай барилдаж, эхний есөн өдөр дараалан давлаа. Башёгийн өмнө сүмогийн мэргэжилтнүүд түүнийг бэлтгэл сайн байгааг онцлон магтаж, хаврын тэмцээнд сайн барилдана гэж дүгнэж байсан нь үнэн болж таарав. Нутгийн аварга нь урамтай барилдаж буй болохоор япончууд ч баярттай байна гэж жигтэйхэн. Энэ мөчийг 20 шахам жил хүлээсэн болохоор аргагүй юм даа. Тэрбээр аварга болсноосоо хойш тайван, өөртөө итгэлтэй барилдаж болсон нь илт анзаарагдаж байна. Энэ нь түүний босоо яваагийн гол шалтгаан. Кисеносато ес дэх өдрийн барилдаанд сахан л өгсөөртэй нь адил озки цолтой явсан



Котошёогикүтэй таарч, хялбархан
давсан.

Котошѳеогикүгийн хувьд энэ башѳд хоѳр оронтой даваанд хүрч байж арслан цолоо эргүүлэн авах учиртай. Харин ѳчигдѳр ѳвдѳг шороодсоноор 6-3 амжилттай болжѳ. Үлдсэн зургаан ѳдрийн дѳрвѳ нь заавал давах хүндхэн даалгавартай хоцорч байна.

Кисеносатог дарах учиртай монгол аваргууд үүргээ хангалттай биелүүлж чадсангүй. Хакүху аварга эхний дөрвөн өдөр хоёр унасны дараа башгт орхисон бол Харумафүжи, Какурюү аваргууд хөдлийн хоёр, гурван удаа өвдөлгөжээ. Харумафүжигийн хувьд өчигдөр нутгийн бөх Аравашин Э.Дөлгөөнд ялагдсанаар түрүү байрын төлөөх өрсөлдөөнөөс үндсэндээ хасагдаж байна. Гэхдээ сүүлчин өдрүүдэд Кисеносатог хоолож, түрүүлэх замыг нь хаах ёстой.

Хэдийгээр аваргууд тааруухан

яваа ч өөр нэг монгол бөх
Кинесенасотог шил даран нэхсээр.
Энэ бол оззқи Тэрүнофужир.
Тэрбээр 2015 оны өдийд
гялалзтал барилдаж, баше бүрт
түрүү байрын төлөө өрсөлдөж
тавсан. Улмаар тэр жилийнхээ
бидугаар сарын тэмцээнд 12-3
амжилтаар түрүүлж, дараагийн
аварга гэгдэж байв. Гэвч хөлдөө
авсан хүнд гэмтэл нь түүнийн
амжилтыг доош татаж, арслан
цолоо алдах аюулд хэдэнтэй
орсон билээ. Харин манай бөх
бүртэл гэмтэлгүй бол хэнтэй ч
арсалдаж чадна гэдгээ энэ удаа
харуулж, ганцхан унаатайгаар
Кинесенасотог шил даран нэхэж
байна.

Сонирхолтой нь шинэ аваргын
хамтаар башёг тэргүүлж буй
бөх нь түүнтэй нэг дэвжээнд
харьяалагддаг эскивакэ Такаясү.
Бие хаа, нуруу турууны хувьд
хэнээс ч дутахгүй энэ бөхийг
өндөр дээд цолд хүрнэ гэж олон

хүн итгэл хүдээлэгдэг. Гэвч доогуур зиндаанд дэндүү удаан барилдсан. Макуүчид гарч ирээд ч дундаж амжилт үзүүлсэн өдийг хүрсэн юм. Харин нэг дэвжээний Кисеносато аварга цолд хүрсэн нь түүний барилдаанд нөлөөлсөн бололтой. Тэрбээр өмнөх башёд 11 давж, сэкивакэ болсон. Энэ удаа нэг ч унаагүйгээр шинэ аваргаарй зуузыг холбож явна. Эрч хүчээ алдалгүй барилдсаар башёд дуусгавал ирэх сарын тэмцээнд озски цолны болзол сонсох нь гаршагүй.

Сонирхуулахад, ёкозүна цолтой барилдсан эхний башёдоо найм дахь өдөр тавиас дээш хувийн амжилтаа үзүүлсэн тав дахь бөх нь Кисеносато болжээ. Өмнө нь Таманооми, Таканасато, Асахифужи, Кахүхо аваргууд ийм амжилт үзүүлж байв. Гэхдээ тэднээс ганц нь буюу 59 дэх ёкозүна Таканасато л тухайн башёдоо түрүүлж байжээ. (31M)

САГСАН БӨМБӨГ

Архангайн залуус үндэсний лигийн аварга

МҮСБХ, МСБХ хамтран зохион байгуулсан 21 аймгийн Үндэсний лигийн тэмцээн таван сар үргэлжилж өндөрлөлөө. Аваргын төлөө баруун бүсээс Архангай аймгийн “Алтан Дорнодын Дайчид”, зүүн бүсээс Сүхбаатар аймгийн “Альянс Тех” баг тунан үлдээд байсан билээ. Тэдний түрүүлж дөрөв хожсон нь аваргын цом хүртэх бөгөөд эхний тулаанд Сүхбаатарын залуус давамгайлсан. Харин үгүйнээс хойш Архангай баг алдаагаа залруулж, удах гурван уулзалтад илүүрхсэн юм. Ингээд тав дахь тоглолтод хожвол лигийн аварга болох мөч тэдний өмнө ирээд байлаа.

Сүүлийн тоглолт тун өрсөлдөөнтэй эхэлсэн. Эхний хагас тэнцүүхэн дууссан бол гуравдугаар үед Архангай бага зэрэг давамгайлсан ч Сүхбаатар амар

бууж өгөх учраа биш гэдгээ харуулан оноог холдуулахгүй байлаа. Тооны харьцаа тун ойрхон явсаар дөрөвдүгээр үед өрсөлдөөн дээд цэгтээ хүрэв. Шийдвэрлэх үед Архангай аймгийн хамгаалагч Э.Дорж-

Арилд хоёр ч удаа бөмбөг тасалж, легионер тоглогч Роберт Тюрнер алсын зайн шидэлтээ оруулсан нь ялагчийн хувь заяаг үндсэндээ шийдсэн. Ийнхүү хүнд хэцүү тоглолтод улсын арслан Р.Пүрэвдагва тэргүүтэй Архангай аймгийн баг 96:92-оор ялалт байгуулж, анхдугаар тэмцээний аваргаар тодорлоо. Тус тоглолтод Архангайгаас О.Энхбаатар 22 оноо, 10 самбар, М.Хэммондс 17 оноо, найман самбар, Р.Тюрнер 15 оноо, долоон самбар авч, долоон оноотой дамжуулалт өгсөн байна. Сүхбаатараас Карл Блэйр 24 оноо, 10 самбар, Э.Дөлгөөн 24 оноо, 14 самбар авсан бол М.Харрис 14 оноо, 10 самбар, Золбаяр 10 оноотой тоглолтыг өндөрлүүлэв. Финалын үнэ цэнэтэй тоглогчоор цувралын турш онцгой тоглолт үзүүлсэн Роберт Тюрнер тодорсон юм.

Архангайн бөхчүүд улсын
наадам болоод Цагаан сарын
барилдааны түрүү аваад буй.
Тэгвэл сагсан бөмбөгийн
талбарт ч тэд одтой байж, олон
чанга учраагаа хожсоор ийн
аваргаллаа. [ЗГМ]



СОДОН СПОРТ

Мянга мянган жилийн түүхтэй ширээний хоккей



Б.Энхжин
ЗГМ

Ширээний хоккей гэхээр манайхан “соц” үеийн орос тоглоомор төсөөлдөг. Түүхийн хуудас сөхвөл эртний Египет, Перс, Грек, Хятад, Японд ширээний хоккейтой төстэй тоглоом байжээ. Эртний Трой хотын түүх судлаач Стенли Фишлер хэмээх эрдэмтэн МЭӨ 1250 оны үед ахей үндэстнүүд ширээний хоккейн өвөг гэж болох атхениан хэмээх тоглоомор нааддаг байсан тухай тэмдэглэлдээ тодорхой бичсэн байдаг. Түүнчлэн манай тооллын 824-961 оны үед оршин тогтнож байсан Баруун Ромын эзэнт улс мөхөхөд суурин дээр нь тогтсон Арабын соёл иргэншил ерөнхийнхнөөс олон зүйлийг, тэр дундаа ширээний хоккейг нь авч үлджээ. Мөн XIII зууны үед чехүүд хоккей-бильярдын холимог гэж болох тоглоомор нааддаг байв. Харин XIX зууны дунд үеэс ширээний хоккей ерөнхийдөө орчин үеийн дүр төрхөө олж, тусгайлан зассан салон байранд тоглоог болжээ.

1932 онд Канадын иргэн Доналд Мурно модоор ширээний хоккейг урласан нь өдгөө Торонто дахь хоккейг "Алдрин танхим"-д хадгалагдаж буй. 1948 онд ЗХУ-ын физиологич Николай Бернштейн нимгэн төмрөөр хүүхдийн тоглоомонд хоккейг хийжээ. Удалгүй хоккейг тус улсын гол спортын нэг болтлоо хөгжиж, 1952

онд зурагтаар анхны хоккейн тоглолтыг шууд дамжуулж, 1954 онд Бобров, Чернышёв нараар удирдуулсан Зөвлөлтийн баг дэлхийн аварга болсны дараа “настойный хоккей”-н эрэлт хэрэгцээ эрс нэмэгдсэн гэдэг. 1953 онд Канадын зохион бүтээгч Фостер Хевит хуванцар хоккей бүтээж, түүнийг нь 1959 онд Шведийн “Stiga” фирм сайжруулан орчин үед бидний тоглодог ширээний хоккейг худалдаанд гаргажээ.

1989 онд Ленинградад “Ширээний хоккей сонирхогчдын клуб”-ийг олон нийтийн байгууллагаар бүртгэж авсан бөгөөд жилийн дараа анхны Европын аварга шалгаруулах тэмцээнийг зохиожээ. Ширээний хоккей өндөр хөгжсөн, дотооддоо тэмцээн уралдаан байнга зохиодог улсууд гэвэл Орос, Латви, Чех, Украин, Финланд, Швед юм. 1990 онд Олон улсын ширээний хоккейн холбоо (IHF) албан ёсоор байгуулагдаж, түүнээс хойш хоёр жил тутам ДАШТ-ээ зохион байгуулж байна. Тэгвэл Table Hockey-н бас нэгэн олон улсын холбоо болох WTHA түүнээс хоёр жилийн хойно байгуулагджээ.

Эцэст нь ширээний хоккейн төрлүүдээс сонирхуулахад Орос болон хуучин Зөвлөлтийн харьяанд байсан орнуудад ROD, луч, соронзон хоккей, Швед болон Европт стига, хойд америкчууд баббл-хоккей, аэро-хоккей, чехүүд бильярд-хоккей зэрэг төрлүүд дэлгэрсэн байдаг гэнэ. [3᠑]

NMC

NATIONAL
NEWS
CORP.

Bloomberg
TV MONGOLIA

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

СЭТГҮҮЛЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд мэдээ сурвалжилга бэлтгэж нийлүүлэх, хөтөлбөрт мэдээ танилцуулах, мэдээний болон техникийн ажилтнуудтай багаар хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Эдийн засаг, бизнесийн тодорхой салбарыг хариуцан ажиллаж, мэдээ сурвалжилга бэлтгэх
- Салбарын бизнес, зах зээлийн судалгаа хийх, биржид бүртгэлтэй компаниудын тайлан, гол үзүүлэлтүүдэд анализ хийх, төлөв таамаг бэлтгэж танилцуулах
- Шууд болон шууд бус хөтөлбөрт мэдээ, сурвалжилга танилцуулах, зочидтой ярилцах, яриа авах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сэтгүүл зүй, хэл шинжлэлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн
- Олон улсын харилцаа, бизнес, санхүү, эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшиж, зах зээлтэй холбоотой аль нэг салбарт ажиллаж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно
- Монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажил хийх туршлагатай
- Мэргэжлийн ёс зүйтэй
- Мэдээллийг цуглуулах, судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай.

ОРЧУУЛАГЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд гадаад мэдээ сурвалжилгыг орчуулан бэлтгэж нийлүүлэх, шууд хөтөлбөрт гадаад мэдээний синхрон орчуулга хийх, гадаад нэвтрүүлчийн орчуулга хийх, бүтээлийн багуудтай хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Олон улсын харилцаа, эдийн засаг, улс төр, бизнесийн салбарын мэдээлэл орчуулах
- Дээрх сэдвээр шууд болон шууд бус хөтөлбөрт орчуулга хийх,
- Олон улсын сүлжээ, агентлагуудаас хүлээн авсан мэдээ сурвалжилга, ярилцлагыг орчуулах, дуу оруулах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Англи хэлний орчуулагчийн бакалавраас доошгүй зэрэгтэй (орос хэлтэй бол давуу тал болно)
- Эдийн засаг, бизнесийн салбар, танин мэдэхүйн нэвтрүүлгийн орчуулга хийх бүрэн чадвар, туршлагатай (аман болон бичгийн орчуулга хийж байсан туршлагатай бол давуу тал болно)
- Англи, монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажилд туршлагатай
- Эдийн засгийн аль нэг салбар, зах зээлтэй холбоотой ажил хийж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Телевизийн салбарт удаан хугацаанд тогтвортой ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Бусадтай харилцах, өөрийгөө зөв илэрхийлэх ур чадвартай
- Интернэтийн орчинд ажиллах, компьютер ашиглах мэдлэгтэй, программ дээр ажиллах чадвартай
- Багаар болон бие даан ажиллах, манлайлах, ажлын ачаалал даах чадвартай байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар батлуулсан байх
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Анкетыг “BLOOMBERG TV MONGOLIA” телевизийн байранд ирж бөглөх бөгөөд бүрдүүлэх материалыг хүлээлгэн өгнө үү.
Хаяг: Блю Скай таур, 4 давхар, № 403, Энхтайваны оргон чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол Улс, Холбоо барих утас: 70102020

ЗГМ ТОВЧОН

» ЧӨЛӨӨТ БӨХ

Японы төвийн бүсийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн нээлттэй тэмцээн Яизү хотын спорт цогцолборт болов. Энэхүү тэмцээнд Монголын зургаан бөх зодоглож, гурван хүрэл медаль хүртлээ. “Алдар” спорт хорооны П.Мөнхтүвшин, Налайх дүүргийн А.Анх-Эрдэнэ, “Их шавь” дэвжээний М.Толуй нар шагналын тавцанд гишгэсэн байна.

» ТЕННИС

Мэргэжлийн теннисчдийн дэлхийн чансаа шинэчлэгдлээ. Германы А.Кербер чансааг удаан хугацаанд тэргүүлсэн С.Ульямсыг байр ухрааж, нэгд бичигдэж эхэллээ. Тэрбээр өнгөрсөн жил Америк, Австралийн нээлттэй тэмцээнд түрүүлж, Уимблдоны финалд шалгарсан юм.

» ХОККЕЙ

ННЛ-ийн “Чикаго”
баг сүүлийн тойрогт
“Колорадо”-г 6:3-аар хожив.
Ингэснээр “Хар харцагууд”
сүүлийн 10 улирал дараалан
плей-оффт шалгарч байна.

» ХӨЛБӨМБӨГ

“Арсенал”-ын дасгалжуулагч А.Венгер ирэх улиралд багтаа үлдэх хүсэлтэй талаар Daily Mail мэдээллээ. Лондоны баг Франц мэргэжилтэнтэй нэг жилийн гэрээ байгуулах бололтой. “Арсенал” сүүлийн жилүүдэд дорвитой амжилт үзүүлээгүй тул түүнийг халагдаж магадгүй гэсэн яриа гараад байв.

» САГСАН БӨМБӨГ

НБА-ийн өнгөрсөн улирлын аварга “Кливленд” сүүлийн тойрогт “Лейкерс”-ийг 125:120-иор буулгаж авлаа. “Лейкерс”-ийн Д.Рассел карьерийн дээд үзүүлэлт болох 40 оноо авсан бол эсрэг багаас холбогч К.Ирвинг 46 оноо түүж, багаа ялалтад хөтөлжээ.

Лавлах

АНХААРУУЛГА

Хүүхдийг буруу тээвэрлэхгүй байхыг сануулав



Г.Оюун
ЗГМ

Сүүлийн үед бага насны хүүхэд зам тээврийн осолд өртөж, амь насаараа хохирох явдал цөөнгүй гарах болжээ. Хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй зорчиход зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг нь автомашин доторх аюулгүй байдлыг хангах хүүхдийн зориулалтын хамгаалах бүс, суудал юм. Учир нь үүнийг хэрэглэж хэвшсэнээр хүүхдийн амь насыг хамгаалаад зогсохгүй замын хөдөлгөөнд зөв, аюулгүй оролцоход ач холбогдолтой юм. Өнгөрсөн онд гэхэд 39 хүүхэд зам тээврийн ослын улмаас нас барсан тоо бий. Эдгээр хүүхдийн 78 хувь нь буруу тээвэрлэлт буюу зориулалтын суудалгүй, бүсгүй эрэг шалтгааны улмаас амиа алдсан байна. Иймд эцэг, эх, асран хамгаалагч та хүүхдэдээ нас, биеийн жин, өндөрт нь тохирсон хамгаалалтын суудал, хамгаалах бүс тохируулагчийг тогтмол хэрэглэж, гарч болзошгүй зам тээврийн ослоос хүүхдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалахыг Замын цагдаагийн газраас анхаарууллаа. [ЗГМ]

тэмцээн

Бүжгийн гайхамшгийг мэдрүүлнэ



Салса, бачата, кизомба бүжгийн дэлхийн хэмжээний фестивалийг Монгол Улсад анх удаа зохион байгуулахаар болжээ. Монголын Салса бүжгийн холбооноос зохион байгуулж буй энэхүү фестиваль “Holiday Inn” зочид буудалд энэ сарын 22-25-нд болох юм байна. Шүүгчээр Румын улсын нэрт бүжигчин Александра Ичим, ОХУ-аас Андрей Корзун нар хүрэлцэн ирэх аж. Дөрөв хоног үргэлжлэх фестивалийн эхний хоёр өдөр багш нараар бүжиг заалган, тэдний үзүүлбэрээс сонирхох боломжтой. Харин 24-ний өдөр фестиваль бачата тэмцээнээр үргэлжилж, 25-нд гала концерт болох юм байна. [ЗГМ]


зөвлөгөө

Хуулийн зөвлөгөө үнэ төлбөргүй өгнө

Энэ оныг “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил” болгон зарласан. Тус ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран сард нэг удаа иргэдэд хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх өдөрлөг зохион байгуулж буй. Энэ удаагийн өдөрлөг өнөөдөр Хан-Уул дүүргийн “Мишээл” , Сонгинохайрхан дүүргийн “Драгон” төв, Баянгол дүүргийн ЗДТГ-ын байранд 09.00-17.00 цагт болно. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР				
	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.00 “Сэтгэлийн гэрэл” Уран сайхны кино	08.00 "Bloomberg Daybreak Asia"	08.05 ЕБС-ийн Теле хичээл	09.30 “Тог тог тог” хүүхдийн нэвтрүүлэг
12.00	11.30 Дэлхийн яруу найргийн өдөрт. Найргийн жим	11.00 "Амжилтад хязгаар үгүй" нэвтрүүлэг	12.05 "Чапаев" ОАК	12.30 "Сонсъё, Суръя, Дагая" нэвтрүүлэг
14.00	14.30 “Амрыг эрье” Дуудлага студи	14.00 "Америк хэрхэн ажилладаг вэ" нэвтрүүлэг	14.10 "Хүрээлэн" амьд ертөнц нэвтрүүлэг	14.00 “Ан амьтдын ертөнцөөр” нэвтрүүлэг
18.00	18.00 Эх сурвалж	18.00 "Бизнесийн төв цэг"	17.50 "Дэлхийн атлас" танин мэдэхүйн нэвтрүүлэг	18.00 “Наашаа цаашаа” нэвтрүүлэг
20.00	19.40 Эхлэх цэг	20.30 “Сайн уу дэлхий” нэвтрүүлэг	21.00 “Зөв үнийг таа” шоу нэвтрүүлэг	21.00 “Оёдлын газрын боловсон эрчүүд” СОАК
22.00	21.05 Цаг үе, үзэл бодол /шууд нэвтрүүлэг/	22.00 "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг	00.00 “Кино миний амьдрал” нэвтрүүлэг	00.00 "Орголт" ОАК

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

1. Хадаж овоолсон өвс
2. Улсын баяр наадамд хамгийн олон удаа түрүүлсэн хурдан хүлэг
3. Тамгатай долоон хутагтын нэг Жамсранжавын цол гуншин
4. "Тусгай салаа" киноны нэгэн

гол дүр

6. Иргэний дайны хөлд нэрвэгдсэн улс
11. Сарлагийн үхрийн гэдэс, хэвлий орчмын үе
12. Ширгэсэн гол усны чулуу бүхий жалга судаг газар

14. Баруун монголчуудыг толгойлж асан хүчирхэг аймаг

ХӨНДЛӨНГӨӨР:

1. АНУ-ын 43 дахь Ерөнхийлөгч
3. Шүглэсэн хий юм, муу зуршил
5. Монгол орны хамгийн өндрөөс цутгадаг хүрхрээ
7. "Говийн" ном
8. Ноёд язгууртны эрхэм дээд цол
9. АНУ-ын эрх баригч хоёр намын

нэг (товчилсон нэр)

10. Олон агуу
11. 1990 оноос өмнөх Засгийн газар (товчилсон нэр)
13. Хүндэтгэлийн зоог шүүс
15. Эрхэс
16. Жимс
17. Төв Азийн гадагш урсгалгүй сав газарт багтдаг гол



Өмнөх дугаарын хариу /03.20

ЗГМ: СҮДОКУ

			5			4	
1	3						8
			4				9
3	6	7			1		4
	4						7
			2		6		
7				5			
8	1			7			3
				8	9	1	

9	1	7	2	3	4	6	5	8
8	3	6	5	9	7	1	2	4
2	5	4	6	8	1	3	7	9
5	7	9	3	6	8	4	1	2
4	2	1	7	5	9	8	3	6
3	6	8	1	4	2	7	9	5
7	8	2	4	1	5	9	6	3
1	9	3	8	2	6	5	4	7
6	4	5	9	7	3	2	8	1

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР



III.21
4°
-7°
7 м/с
5 м/с

Бага зэргийн цас орно



III.22
3°
-7°
9 м/с
8 м/с

Үүлшинэ



III.23
1°
-9°
8 м/с
7 м/с

Үүлшинэ




III.24
-1°
-12°
9 м/с
8 м/с

Үүлшинэ




III.25
1°
-13°
6 м/с
4 м/с

Үүлшинэ



ЗГМ: КОМИКС



ҮЗВЭР



Б.Цогнэмэхийн “Тэнгэрийн хүү” жүжиг энэ сарын 25-нд 18.00 цагт болно. У.Шекспирийн “Гамлет”-ыг гуравдугаар сарын 27-нд 19.00 цагт, М.Сервантесийн “Кихот ноён” жүжгийг гуравдугаар сарын 29-нд 19.00 цагаас, В.Хюгогийн “Парисын дарь эхийн сүм” жүжгийг энэ сарын 30-ны 19.00 цагаас тус тус тоглоно.



Э.Мөнхтөрийн “La Mia voce” сонгодог концерт энэ сарын 22-нд 19.00 цагт болно. Олон улсын театрын өдөрт зориулсан гала концерт энэ сарын 26-нд 17.00 цагт болно. “Harmonica moods” жааз аман хуур хөгжмийн тоглолт энэ сарын 30-нд 19.30 цагт болно.



“Big show” хэмээх stand up comedy тоглолт энэ сарын 31-нд 19.00 цагт болно.



“Гочлол болон цөөхүүл” хөгжмийн концертыг энэ сарын 30-нд 19.00цагт тоглох гэж байна.



Сурагчдын амралтыг тохиолдуулан 0-6 насны хүүхдүүдийг үнэ төлбөргүй амраахаар болжээ. Мөн сувиллын нийт үнийн дүнгийн 15-25 хувийн хямдралыг зарласан байна.



“Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ нь “IC Creative Division” студитэй хамтран АНУ-ын ЭСЯ-ны дэмжлэгээр “Сайхан бие 2.0” гэрэл зургийн үзэсгэлэнг “UB Art” галерейд нээжээ. Уг үзэсгэлэн энэ сарын 26-ныг дуустал үзэгчдийн мэлмийг баясгах аж.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 24

Хаврын тэргүүн хар бар сарын гурван хөх мэнгэтэй улаагчин хонь өдөр. **Үс засуулбал:** Өвчин эмгэг ирнэ **Наран ургах, шингэх:** 06.58-18.58 **Барилдлага:** Үхэх **Шүтэн барилдлага:** Хүрэлцэхүй **Суудал:** Огторгуй

Аргын тооллын гуравдугаар сарын 21, Ангараг гараг. Билгийн тооллын 24, Суулга одтой, улаагчин хонь өдөр.

Өдрийн наран 06.58 цагт мандан, 18.58 цагт жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лус тахиx, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Цөөрөм байгуулах, сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



УБ-Москва	13.50	14.28
Москва-УБ	21.35	07.30
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Эрхүү	21.10	02.40
УБ-Замын-Үүд	17.20	07.05
Замын-Үүд-УБ	17.35	07.55
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48



УБ-Бээжин	15.30	17.35
Бээжин-УБ	11.55	14.30
УБ-Бишкек	11.25	13.55
Москва-УБ	20.05	00.00
УБ-Сөүл	00.00	03.55
Сөүл-УБ	13.20	16.05
УБ-Хонг Конг	07.51	12.25
Манжуур-УБ	16.50	19.25
УБ-Манжуур	16.50	19.25

Мексик Трампын ханыг эсэргүүцэхийг дотоодын компаниудад уриалав

Цагийн хөлс нь өндөр тендер Мексикийн компаниудад эх оронч үзлээ хойш тавих шалтгаан болж болзошгүй. > 10

Мужийн шинэ захирагч шашны мөргөлдөөн дэгдээх эрсдэлтэй

Ирэх ням гарагт тангарах өргөх Адитьянатх нь хинду шашны хамгийн маргаантай үндсэрхэг урсгалын нэгийг тэргүүлдэг. > 10



Шинэ дугаар
ХУДАЛДААНД ГАРЛАА!
+976 77074646

Ус хар алтнаас ч үнэтэй таваар болно



The New York Times©

Эндрю Уорд

Хөдөө аж ахуй, үйлдвэр, хүн зонын өсөн нэмэгдэж буй усны хэрэглээ нь чандмань эрдэнийн төлөөх өрсөлдөөн хар алтныхаас илүү үнэ цэнэтэй болж буйг Францын нийтийн шугам сүлжээний Suez компанийн гүйцэтгэх захирал онцоллоо.

Жан Луи Шоссаде энэ сард

General Electric-ийн ус түгээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг GE Water компанийг 3.4 тэрбум ам.доллараар худалдаж авахаар болсноо мэдэгдээд, “Усны хомсдол нь эрчим хүч, уул уурхай, эм болоод химийн үйлдвэрлэлд тулгарч буй хамгийн том асуудал” хэмээв.

Ус газрын тосноос ч үнэтэй

таваар болох өдөр ирэх болов уу гэсэн FT-ийн сурвалжлагчийн асуултад ноён Шоссаде “Ирээдүйд эргэлзээгүй” хэмээн хариулжээ.

Тэрбээр мөн 2035 он гэхэд дэлхийн нийт хүн амын 40 хувь нь усны хомсдолтой газар нутагт аж төрнө гэх төлөвийг иш татав. Ингэснээр компаниуд, хөдөө аж ахуй, тэр ч бүүхэл энгийн иргэд

хүртэл усны төлөөх өрсөлдөөнд орох аж.

Түүнийхээр “Засгийн газрууд үйлдвэрлэгчдэд энд үйл ажиллагаа явуулж болох ч гүний ус татаж болохгүй гэж хэлж байна. Тиймээс компаниуд хаягдал усаа дахин ашиглах мөн цэвэршүүлж хэрэгцээгээ хангахаас өөр сонголтгүй” хэмээв.

Аж үйлдвэрийн салбарт эргэлдэж буй усны үйлчилгээний зах зээл одоо 95 тэрбум еврогоор хэмжигдэж байна бөгөөд уг зах зээлийн тэлэлт урт хугацаанд жилд таван хувь байх төлөвтэй. Өөрөөр хэлбэл, жилд гурван хувь байна хэмээн таамаглаж буй дэлхийн эдийн засгийн өсөлтөөс давах юм.

Suez-ийн аж үйлдвэрийн усны салбарт ийн хөрөнгө оруулалтаа чиглүүлэх болсон нь олборлох түлшнээс татгалзаж буй дэлхий нийтийн хандлагатай хөл нийлүүлж буйн илрэл. Яагаад гэвэл энэ нь Suez-ийн голлох хувьцаа эзэмшигч болох Францын эрчим хүчний Engie групп газрын тос, байгалийн хийн олборлолт, нүүрсний станцын салбарыг орхихоор шийдэж байгаагаас өөргүйг алхам юм.


Тэгээд ч аж үйлдвэрийг усаар хангах дэд бүтцийн үйлчилгээг уламжлалт шугам сүлжээтэй харьцуулахад бизнесийн илүү том боломж олгож буй. Учир нь дэлхийн усны нийт хэрэглээний таван хувийг хувь хүн, 20 хувийг аж үйлдвэрүүд бүрдүүлдэг бол үлдсэнийг нь хөдөө аж ахуйд хэрэглэдэг байна.

GE Water компани нь Exxon-Mobil, Pfizer болон Nestle зэрэг компанид усны хэрэглээ, гүйцэт ашиглалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг. АНУ-ын компаниудын орлогын бараг 50 хувь нь АНУ-аас төвлөрдөг хэдий ч хөгжиж буй орнууд, нэн ялангуяа Хятадад усны үйлчилгээнээс олох орлого нэмэгдэх төлөвтэй байгааг ноён Шоссаде тэмдэглэв.

Suez 3.4 тэрбум ам.долларын санхүүжилтийн тодорхой хэсгийг Канадын тэтгэврийн Caisse de Dépôt et Placement du Québec сантай байгуулсан түншлэлийн хүрээнд шийдэх юм байна.



Хөнгөн цагаан үйлдвэрлэгчид Их 20-ийг лоббидов



Хенри Сандерсон, Хенри Фой

Энэ зун Хамбург хотноо болох Их 20-ийн уулзалтыг угтаж Хятадын түүхий эдийн илүүдлийн эсрэг дорвитой арга хэмжээ авахад чиглэх дэлхийн хэмжээний форум зохион байгуулахыг Хөнгөн цагааны худалдааны нийгэмлэгүүдийн олон улсын эвсэл шаардаж байна.

Rio Tinto болон Alcoa зэрэг уул уурхайн томоохон компаниудын төлөөлөл болох Канад, Европ, АНУ-ын нийгэмлэгүүдийн эхлүүлсэн эл санаачилгыг Хятадын хөнгөн цагааны үйлдвэрлэлд орон зайгаа алдсан Оросын бизнес эрхлэгчид ч дэмжиж байна.

Төлөөлөгчид Их 20-ийн удирдагчдад хүргүүлсэн захидалдаа “Үүсээд байгаа нөхцөл байдлын улмаас олон улсын худалдааны замбараагүй урсгал улс орнуудыг хүнд байдалд оруулахаас гадна глобал тогтвортой байдал алдагдах аюултай” хэмээжээ.

Хятад бол дэлхийн түүхий эдийн хамгийн том үйлдвэрлэгч. Гэвч энэ жил агаарын бохирдолтой холбоотойгоор анх удаа л хойд муж, хотуудын үйлдвэрлэлийн хэмжээг бууруулахаа илэрхийлсэн. Энэ амлалт нүүрс болон гангийн үйлдвэрлэлээ бууруулахад авсан арга хэмжээтэйгээ адил үр дүнд хүрнэ гэсэн найдвар төрүүлж буй.

Таван жил үргэлжилсэн уналтын дараа бага зэрэг сэргэсэн үнээс ангид авч үзвэл Хятад үйлдвэрлэлийн багтаамжаа бууруулна гэж арай амлаагүй гэдгийг шинжээчид анхаарууллаа.

АНУ-ын хөнгөн цагааны

нийгэмлэгийн бодлого хариуцсан дэд тэргүүн Чарльз Жонсон “Коммунист Засгийн газар эрэлтээс давсан үйлдвэрлэл нь асуудал дагуулж буйг хүлээн зөвшөөрч, шийдвэрлэх арга зам танилцуулсан хэдий ч өнөөг хүртэл авсан арга хэмжээ гэхээр зүйл алга” хэмээв.

Өнгөрсөн сард Хятадын Байгаль орчны яам болон орон нутгийн захиргаанаас хойд хэсгийн 28 хотын үйлдвэрлэлийг 30 хувиар бууруулахыг шаардсан албан бичиг гаргасан юм. Харин энэ бүс нутаг дэлхийн хөнгөн цагааны үйлдвэрлэлийн 20 хувийг бүрдүүлдгийг Goldman Sachs-ийн шинжээчид онцлов.

2009-2015 оны төгсгөл хүртэл тулсан доод үнэдээ хүрээд байсан хөнгөн цагааны ханш энэ жил 11 хувиар өсөж, тонн нь 1916.5 ам.доллар хүрээд байна.

Хөнгөн цагаан металлыг Ерөнхийлөгч Доналд Трамп ч гэсэн ноён Обамагийн адил чухалчлан авч үзэх болов уу хэмээн ноён Жонсон хэлэв. Цагаан ордныг орхихоосоо өмнө Обамагийн засаг захиргаа Бээжинг хөнгөн цагааны үйлдвэрлэлдээ татаас олгодог хэмээн Дэлхийн худалдааны байгууллагад элсэхийг эсэргүүцэж байсан билээ.

Москва хөнгөн цагааны үйлдвэрлэгчдийг хамарсан ОПЕК-ийнх шиг картель зохион байгуулахаар төлөвлөж буйгаа өнгөрсөн сард тус улсын Худалдааны сайд мэдэгдсэн нь Орос ч мөн цухлаа барьж дийлэхээ больсны илрэл юм.



ТНААД-ийн эсрэг жагсаалд балчирууд ч нэгджээ

Том Мичелл, Шиньнин Лю

АНУ, Өмнөд Солонгосын байгуулах гэж буй пуужингийн хамгаалалтын системийг болиулах гэсэн Хятадын эсэргүүцэл дахин шинэ фронтоор хүрээгээ тэлж байна. Хятадын уудам газар нутгийн өнцөг булан бүрт өрнөөд буй уг эсэргүүцэлд долоон настнууд ч нэгдлээ.

Хэбэй мужийн Яли хотын Century Star бага сургуулийн 400 сурагч, багш ТНААД-ийн эсрэг жагсаж эхлэв. Цахим орчинд тархсан нэгэн дүрс бичлэгт 12 наснаас томгүй сурагчид Өмнөд Солонгосын бүтээгдэхүүнийг худалдаж авахгүй, ТНААД-ийг сөрөн зогсохоо илэрхийлэн, андгай өргөж байв.

ТНААД-ийг байрлуулснаар ямар аймшигтай үр дагавар гарахыг нэгэн багш айдас төрүүлэм зургаар илэрхийлэн жагсаалд барьжээ. Тэрбээр “Өмнөд Солонгос бол манай хөрш. Дайн боллоо гэхэд АНУ Хятадыг цус урсгасан тэмцлийн газар болгож хувиргана. Хятадын хувьд ТНААД бол үхлийн аюул” хэмээн ярих.

Багш нар сурагчдаа Өмнөд Солонгост очихгүй, телевизийн нэвтрүүлгүүдийг нь үзэхгүй, тус улсын жижиглэн худалдааны Lotte компанийн борлуулдаг гоо сайхны болон ямар ч төрлийн бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байхыг ухуулж буй аж. Учир нь Lotte-ийн толгой компани өөрийн эзэмшлийн газраас ТНААД системийн зарим техник хэрэгслийг байрлуулахад найр тавьсан гэж үзжээ. Бичлэгт багш оюутнуудаас “Бид ингэж чадна биз дээ? гэхэд, сурагчид хариуд нь “чадна!” хэмээн гурвантаа хариулж байв.

ТНААД систем бол Өмнөд Солонгосын аюулгүй байдалд, тэр тусмаа Умард Солонгос баллистик пуужин туршилтаар ойр ойрхон харваж байгаа энэ үед амин чухал гэсэн байр суурийг Сөүл баримталж буй. Үүнийгээ ч шууд илэрхийлж байгаа билээ. Өнгөрсөн сард их удирдагч Ким Жөн Унын эцэг нэгтэй ахыг Малайзад хөнөөсөн хэрэг явдал



The New York Times©

ч өмнөдчүүдийн түгшүүрийг улам зузаатгасан. Ким Жөн Намыг “VX nerve agent” гэгддэг зөвхөн зэвсэгт хэрэглэдэг химийн бодисоор хөнөөсөн гэж Пхеньян үзэж буй билээ.

Харин Хятадын тал ТНААД нь бүс нутгийн хүчний тэнцвэрийг алдагдуулж болзошгүй гэж үзэж буй учраас ийнхүү тэмцэж байгаа юм. Бээжингийн айж буй цор ганц шалтгаан бол пуужингаас хамгаалах систем нь эцсийн дүндээ тус бүсэд АНУ, Өмнөд Солонгос, Японы гурван талт батлан хамгаалах холбоог бий болгож болзошгүйд байгаа хэмээн шинжээчид үзэж байна.

Энэ түвэгтэй асуудлыг долоон настай балчир сурагчид ойлгохгүй нь мэдээж. Гэхдээ Century Star бага сургууль зарчмын хувьд эсэргүүцэлд нэгдэх нь зөв зүйл хэмээн ойлгож байна. Тус сургуулийн багш болох Шин Шяофен “Хүүхдүүдэд багаас нь эх оронч боловсрол олгох учиртай. Сурагчдын эцэг, эх ч дэмжиж байгаа” хэмээн FT-д

ярьжээ.

Бээжин дэх Өмнөд Солонгосын Элчин сайдын яамны төлөөлөгч “Балчир сурагчдыг улс төрийн зорилготой жагсаалд хамруулж байгаа нь үнэхээр харамсалтай. Хятадын Засгийн газар хоёр талын ойлголцлыг хангахын тулд зохистой арга хэмжээ авах ёстой” хэмээн мэдэгдэв.

Мөн эл явдлыг эсэргүүцэж, бага сургуулиудыг ийм жагсаалд оролцохыг турхирахгүй байхыг илэрхийлсэн захидал Хятадын боловсролыг яаманд хүргүүлснээ Элчин сайдын яамны төлөөлөгч нэмж хэлжээ. Гэвч яамнаас албан ёсны хариу өгөөгүй байгаа аж.

Иймэрхүү жагсаал Хятаддаа ч маргаантай асуудал. Ноён Шинийн сургуулийн жагсаалыг нэгэн этгээд цахимаар “Энэ бол тархи угаалтын харгис хэлбэр” гэж шүүмжилсэн бол өөр нэг нь “Үзэн ядалт түгээх ивүүр нь хүүхдүүд болох учиргүй. Энэ бол галзуурал” хэмээжээ.

Бээжингийн их сургуулийн гадаад хэлний профессор Цяао

Мү “Сурагчдыг тэмцэлд дуудах аливаа арга хэмжээг сургууль зохион байгуулах учиргүй. Хятад, Өмнөд Солонгосын харилцаа сайжирвал хүүхдүүддээ буцаад юу гэж тайлбарлах болж байна?” гэж гайхаж байна.

Lotte групп болон Өмнөд Солонгосын бусад компанийн эсрэг хөдөлгөөн Хятадад улс төрийн харилцаа ямар хурдан өөрчлөгдөж буйг илэрхийлж байна. Гуравдугаар сарын 8-ны байдлаар Lotte-ийн 40 дэлгүүр хаалгаа барьсан бөгөөд ихэнх нь галын аюулгүй байдлын шаардлага хангаагүй зэрэг шалтаг төдий шалтгаанаар хаагджээ.

Уг нь арваннэгдүгээр сард Хятадын төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Lotte группийг ядуу бүс нутгуудад сургууль байгуулах санхүүжилт олгож, зутруу амьдралтай хүүхдүүдийн боловсролд анхаарч буйг нь магтан дуулж байсан билээ.





BBM©

Сербийн мэдээллийн хэрэгсэл дэх Кремлийн оролцоо

◀ Балканы хойг дахь “гаднын эрүүл бус нөлөө” нь бүс нутгийн улсуудад тогтворгүй байдлын шалтгаан болж буйг Европын зөвлөлийн ерөнхийлөгч Доналд Туск анхааруулж байв. ОХУ нь Балканы бүс нутагт тогтворгүй байдал, Европын холбоонд үл итгэх нөхцөл үүсгэж, тус холбоонд элсэх Сербийн хүчин чармайлтыг талаар болгох зорилгоор Sputnik зэрэг 20 гаруй мэдээллийн хэрэгсэл ажиллууулж байгааг НАТО-гийн тал баримтлагч

СЕАС судалгааны хүрээлэнгийн захирал Елена Милич тайлбарлав. Өөрийгөө пан-славын ахан дүүсийн өмөг түшиг хэмээн тайлбарлагч Москва нь Косовогийн газар нутгийн маргаанд Белградыг дэмжиж, 1995 оны Сребреницагийн хядлагатай уялдан НҮБ-аас гаргасан шийдвэрт хориг тавьж байлаа. Үүнээс шалтгаалан Европын холбоонд Сербийг элсүүлэхийг гишүүн улсууд төдийлэн дэмжихээ больсныг санал асуулга харуулав. Долоон сая хүн амтай тус улсад ажилгүйдэл буурсаар

байгаа ч хөдөлмөрийн чадвартай иргэдийн 20 хувь нь эрхэлсэн ажилгүй хэвээр. Сербчүүдийн олонх нь өрнөдтэй тогтоосон эдийн засгийн харилцаагаа чамлаж, Оросын хөрөнгө оруулалтыг хэтрүүлэн үнэлдэг. Тус улсын иргэдийн 25 хувь нь ОХУ-ыг гол донор орноо хэмээн үздэг. Хэрэг дээрээ Москва нь Сербид хөрөнгө оруулагч гол таван улсад ч багтдаггүй. Москвагийн стратегид өрнөдийн зүгээс хариу өгч эхэллээ. Түншүүд дотор нь Тагнуулын төв газрын захирал байсан генерал

Дэвид Петреус багтдаг, АНУ-ын хөрөнгө оруулалтын КKR компани Сербид телевизийн суваг, кабелийн телевиз, интернэт компани эзэмших боллоо. Мөн хаагдсанаас нь хойш долоон жилийн дараа буюу ирэх жилээс BBC Белградад серб хэлээр дамжуулдаг мэдээллийн сувгаа дахин эхлүүлэхээр төлөвлөж байна. Их Британийн Засгийн газар эхний ээлжинд уг сувгийг жил тутам 600 мянган фунт стерлингээр санхүүжүүлнэ. BBC Serbia нь төсөвтөө захирагдан орон нутгийн 20

сэтгүүлч ажиллуулж байгаа нь 30 сэтгүүлтэй Sputnik-тэй харьцуулахад цөөн. Sputnik агентлаг төсвийн зардал, вэб-сайтад нь ханддаг зочдын тухай тодорхой тоо хэлэхээс татгалзав. Нидерландын энхийг сахиулагчид Сребреницад Боснийн 8000 иргэний амийг хөнөөсөн хэмээн буруутгагч, Туркийн Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоаныг өргөмжлөн магтсан нэвтрүүлгийг саяхан Sputnik нийтэлсэн. Англи хэл дээрх сайтад нь өрнөдийн гүрнүүд Албанийг өргөжүүлэх зорилгоор

“Скопьегийн гудамжинд цус урсгах эрмэлзэлтэй” хэмээн тайлбарлажээ. Москвагийн дэмжлэгт агентлагуудын мэдээлэл нь ОХУ-ын Ерөнхийлөгч Путинийг баатар болгон өргөмжилсөн, эсвэл хараан зүхсэн орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдийнхээс хавьгүй үнэмшилтэй хэмээн үзэх нь Сербийн сэтгүүлчдийн дунд нийтлэг.

Хуучин оффис нь 2011 онд татан буулгах үед BBC-гийн сэтгүүлчийн ажлаасаа хагацсан Урос Бобич зэрэг хөтлөгч эдүгээ Сербийн сонинуудад, бусдаас хамааралгүй ажиллах болсны ачаар хавьгүй их орлоготой болжээ.

“Манай мэдээллийн хэрэгсэл хэт туйлшрамтгай” хэмээн хуучин Ерөнхийлөгч Слободан Милошевичийн үед Сербийн төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн компанийг удирдаж байсан Милорад Вукелич тайлбарлав. Сербийн Засгийн газар, ОХУ-ын тал баримталдаг, долоо хоног тутмын Rssat сэтгүүл эрхлэн гаргаж буй тэрбээр доромжлон гутаасан контент цацагч өрсөлдөгч нараа “Хогнууд” хэмээн нэрлэж байлаа. “ОХУ-ыг дэмждэг мэдээллийн хэрэгсэл уншигчдын анхаарлыг татаж чадаад байгаа. Харин өрнөдийн тал баримтлагч мэдээллийн хэрэгсэлд ийм чадвар байхгүй. Энэ л гол ялгаа” хэмээн тэрбээр өгүүлсэн юм. Ноён Вукелич уншигчид нь Сербийг Европын холбоонд элсэнэ гэдэгт аль дээр үед итгэхээс байсныг анхааруулав.

Sputnik агентлаг шинэ мэдээ, мэдээллийг ОХУ-ын өнцгөөс харах гэсэн орон нутгийн хэрэглэгчдийнхээ хүслийг л хангах үүрэгтэйг хатагтай Милинчик тайлбарлав. “Тусгаар тогтносон улс энэ зэргийн юмаа өөрсдөө шийднэ” хэмээн тэрбээр өгүүлж



Мексик Трампын ханыг эсэргүүцэхийг уриалав

Жуд Уэббер

АНУ-ын талаасаа “Гоо зүйн хувьд аятайхан харагдахуйц” хана хашлага бүтээх ажлын үнийн санал авахад арав хоногийн хугацааг Цагаан ордон зарлав. Үүнтэй уялдан Мексик улс өөрийн компаниудад ичих нүүртэй байж, Трампын ханыг босгох тендерт оролцохоос татгалзахыг уриаллаа. АНУ, Мексикийг зааглаж буй 3200 километр урттай хилийн зурвас эмжсэн хана босгох тендерт 700 компани оролцохоор бүртгүүлээд байна. Шинээр байгуулах 30 фүүт буюу 9.1 метрээс дээш өндөртэй хана нь болзошгүй цагаач нар авирах, доогуур нь ухаж нэвтрэх аргагүй хаалт болох юм. Ноён Трампын “Америк эн тэргүүнд” стратегид нийцүүлэн хана босгох барилгын материалыг “Америкаас худалдаж ав” уриатай тендерээр нийлүүлнэ. Мексикийн гадаад хэргийн сайд Луис Видегарай компаниудад эх орноо тэргүүнд тавьж, тендерт оролцох хүслээ нухацтай эргэцүүлэхийг анхааруулав. Ноён Трамп төлөхийг шаарддаг ч Мексик улс хана барих зардал гаргахаас эрс татгалзсан. “Тендерийг эдийн засгийн боломж хэмээн ойлгож буй компаниудад хандан хүн мөсөө бодолцож үзээрэй хэмээн анхааруулъя. Учир нь та бид эдийн засгийн тухайд бус, хоёр улсын харилцаанд үүсэх гэж буй, эцсийн хариуцлагыг нь бүгдээрээ хамт үүрч таарах, нөхөрсөг бус, ноцтой арга хэмжээний тухайд ярьж байна” хэмээн сайд өгүүлэв. Мексикийн гэрэлтүүлгийн Ecomvelosity компани тендерт оролцох сонирхолтой ч АНУ-д үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн ашиглах заалтаас шалтгаалан ялалт байгуулах боломж бага. АНУ-ын ажлын байрыг булааж байна хэмээн Трамп шүүмжилсэн, бага өртөг зардалтай улс болох БНХАУ-аас аж үйлдвэрлэлийн

зориулалттай гэрэлтүүлэг худалдан авч нийлүүлэх саналыг тус компани тавиад байгаа. Cementos de Chihuahua компани ч ханган нийлүүлэгч болж чадахаа мэдэгдсэн. Бүтээгдэхүүнийхээ 20 хувийг АНУ-д борлуулдаг, барилгын материалын Cemex компани нийлүүлэлт хийх хүсэлтэй талаар тус компанийн тэргүүн саяхан сэтгүүлчдэд тайлбарласан нь Мексик даяар ширүүн шүүмжлэл дэгдэхэд хүргэв. Шүүмжлэлтэй холбогдуулан Cemex компани хана барих барилгын ажилд оролцох гээгүйгээ нэмж тайлбарлах хэрэг гарсан юм. Тус компани ноён Трампын төлөвлөсөн дэд бүтцийн ажил хэрэгжих явцыг анхааралтай ажиглаж байна.



BBM©

Ажилчдын өдрийн цалингийн доод хэмжээ 80.04 песо буюу одоогийн ханшаар 4.19 ам.доллар байдаг Мексикт цагийн хөлс нь 10.20 ам.доллараас эхлэх тендерийн баримт бичиг эх оронч үзлээ хойш тавьж, төөргөөр олдсон хишгийг эдлэ гэсэн уриа болж болзошгүй. Гэхдээ барилгын материалыг “Америкаас худалдаж ав” гэсэн шаардлагыг тендерт тавьсан нь ноён Трампын стратеги юм. Цагаач нар нэвтрэхээс сэргийлэх ажлыг “цэрэг дайны ажиллагаа” хэмээн тодорхойлсон Ерөнхийлөгчийн тодорхойлолтод нийцүүлэн “Хананы умард зүг харсан хэсэг нь гаднын халдлагад гэсвэртэй бат бөх, арматур бэхэлгээтэй байх” гэсэн шаардлагыг тендерийн

нөхцөлөөр зааж өгчээ. Үнийн санал ирүүлэгчдээс АНУ-ын өмнөд хил дээрх тактикийн дэд бүтэц ямар байх ёстой талаар өөрсдийн ойлголтоо бичихийг хүссэн байна.

Төслийн тендерт “АНУ-ын Гааль, хилийн харуулын албанаас тавьж буй техникийн шаардлагад нийцсэн, эс бөгөө уг шаардлагаас илүү гарахуйц шинэлэг арга технологиор хилийн хана босгож чадах гэрээлэгчийг тус алба хайж байна” хэмээн тайлбарлажээ.

Ханын өндөр 30 фүүт буюу 9.1 метр байх ёстой ч “зарим газар 18 фүүтээс (5.4 метр) дээш өндөртэй байхаар тооцож болно” хэмээн тендерийн шаардлагад заажээ. Хана нь авирах боломжгүй гөлгөр, ханын орой хэсэг нь гох дэгээ

хэрэглэх аргагүй үргэлж хийцтэй байх ёстой. Доогуур нь хонгил ухах боломж олгохгүйн тулд дор хаяж зургаан фүүтийн (1.8 метр) гүн суурьтай байх талаар баримт бичигт тайлбарласан байна. Ханын АНУ руу харсан тал нь гоо зүйн хувьд үзэмжтэй, орчныхоо нөхцөлд нийцсэн, өнгөлөг, авирч үл болох хээ зэрэгтэй байх учиртайг мөн дурдлаа.

Ноён Трамп хилийн зурвасыг хамгаалахаар яарч буй, тендерийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй зэргээс шалтгаалан сонирхогч талууд “Давчуу хугацаанд гүйцэтгэх төлөвлөгөө”-г зардлын тооцоотой нь хамт ирүүлэхийг тендерийн шаардлагад зааж өгсөн



BBM©

Мужийн шинэ захирагч шашны мөргөлдөөн дэгдээх эрсдэлтэй

Саймон Мэнди, Жёсна Сингх

Энэтхэгийн эрх баригч нам хинду шашинт, маргаантай эрхмийг хүн амынхаа тоогоор улсдаа тэргүүлдэг мужийн удирлагад томилсон нь үндэсний цөөнх мусульманчуудыг ялгаварлан гадуурхахад хүргэж болзошгүй нөхцөл үүсгэв. Бхаратиа Жаната нам энэ сард Уттар Прадеш мужийн сонгуульд ялалт байгуулмагцаа шашны хүчирхийллийг дэгдээгч хэмээн шүүмжлэгчид нь буруутгадаг, Энэтхэгийн парламентын гишүүн Йоги Адитьянатхыг тус мужийн тэргүүн сайдаар томилжээ. Засгийн газар байр сууриа ашиглан хинду үндсэрхэг үзэлтнүүдийг дэмжиж, тус улсын 170 сая мусульман цөөнхийг гадуурхах гэж байна хэмээн Ерөнхий сайд Нарендра Модигийн томилгоог эсэргүүцэгч сөрөг хүчин шүүмжлэв. Уттар Прадеш мужийн хүн амын 20 хувийг эзэлдэг мусульманчуудыг аймшиг дүүрэн ирээдүй хүлээж байгааг Жамму Кашмир мужийн тэргүүн сайд байсан Омар Абдулла Twitter-г бичжээ. Гужарат мужийн тэргүүн сайд ноён Модиг 2002 онд 800 мусульманы амь үрэгдсэн аймшигт хэрэг дэгдэхээс сэргийлж чадаагүйг дэлхий нийт шүүмжилж, АНУ нутаг дэвс-

гэртээ нэвтрүүлэхээс татгалзсан. Шашин, кастаар ялгаварласан хүчирхийллийг буруутгахдаа цаг алддаг хэмээн шүүмжлүүлж ирсэн ноён Модиг Энэтхэгийн ерөнхий сайдын хувьд байдлыг хурцатгах улс төрийн ноцтой арга хэмжээ авахаас зайлсхийсээр өдий хүрчээ.

Ирэх ням гарагт тангараг өргөх 44 настай Адитьянатх нь хинду шашинтны хамгийн маргаантай үндсэрхэг урсгалын нэгийг тэргүүлдэг. “Мужийн тэргүүн сайдаар бусдад занал учруулаад байхааргүй, ач холбогдол харьцангуй багатай хүнийг томилдог байсан цаг өнгөрлөө. Уттар Прадеш мужийн удирдлагад ийм эрхэм гарч байсан түүхгүй. Энэ мужид юу болж өнгөрөх нь нийт Энэтхэгт нөлөөтэй” хэмээн Шинэ Делийн ойролцоох Ашока их сургуулийн улс төрийн ухааны профессор Жилл Верье тайлбарлав.

Уттар Прадеш нь 2011 оны тооллогоор 200 сая хүн амтай гарч, улсдаа тэргүүлсэн. Энэ тоо эдүгээ бүр ч өссөн байх ёстой. Тус мужийн дорнодод оршдог Горакпур хотын сүмийн санваартан Адитьянатх нь 1998 оноос хойш Энэтхэгийн парламентын гишүүнээр ажиллаж байна. Түүний үндэслэсэн Хинду Юва Вахини хэмээх

идэвхтэн залуучуудын бүлэглэлийн гишүүд хэд хэдэн удаагийн хүчирхийллийн самуунд нэр холбогджээ.

Энэтхэгийн хот хөгжүүлэлтийн сайд Венкайя Найдуг иргэдийн түгшүүрийг намжааж, ноён Адитьянатхыг “Чин шударгуу эрхэм” хэмээн үнэллээ. Ноён Найдуг шинэ томилгоог “Энэтхэгийн каст, шашны бодлогыг сөрсөн арга хэмжээ” хэмээн тайлбарлаж байна.

Харин Шинэ Дели дахь Улс төрийн бодлогын судалгааны төвийн шинжээч Ниланжян Сиркар уг томилгоог ноён Модиг энэ сард тус мужид байгуулсан ялалтаа бататгаж буй хэрэг хэмээн үзлээ. Ноён Модигийн Бхаратиа Жаната нам сонгуулиар Уттар Прадеш мужийн парламентын 403 суудлын 325-ыг нь авсан юм.

Ганц ч исламын шашинтан нэр дэвшүүлэлгүйгээр ялалт байгуулсан тус нам хинду олонхын эрх ашгийг хамгаалахаас өөрийг хийхгүй хэмээн тэрбээр анхааруулж байлаа. Эдүгээ Уттар Прадеш мужийн мусульманчууд “улс төрийн бодлого бидэнд шударга байх уу... хууль ёс бидэнд шударга үйлчлэх үү?” гэсэн асуулт л тавих болно хэмээн ноён Сиркар тайлбарласан юм.



Эдийн засаг

ТЕХНОЛОГИ

Технологийн талбар, мөнгөний авдар

Ухаалаг төхөөрөм-жийн тоглоомууд дэлхийг байлдан дагуулаад байна

Б.Байгал
@baigalZGM

Эртний танилууд эргэн иржээ. Хориод жилийн өмнө багачуудыг байлдан дагуулж байсан “Pokemon”-ий баатрууд шинэ зуунд эргэн ирж, хүүхэд, залуусыг татаад эхэллээ. Бодит болон хийсвэр ертөнцийг хослуулсан энэ тоглоом хэдхэн хоногийн дотор дэлхий даяар түгж, олон сая хэрэглэгчийн хүртээл болов. Японы “Nintendo” компанийн уг бүтээл нээлтээ хийснээс долоохон хоногийн дотор АНУ-д 26 сая хүнийг өөртөө элсүүлсэн. Энэ нь нийгмийн сүлжээний тэргүүлэгчид болох “Facebook”, “Twitter”-ийн эхэн үетэй харьцуулахад хэд дахин өндөр үзүүлэлт болохыг “Survey Monkey”-д дурджээ. Ийнхүү саяар тоологдох хэрэглэгчтэй гараанаас гарсан “Pokemon Go”-г сонирхогчдын тоо өдгөө тэрбумыг даваад байна. Түүгээр зогсохгүй, хэрэглэгчид нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг цагаасаа ч ихийг энэ тоглоомд зарцуулж байгаа бөгөөд хэт донтох тохиолдол ч гарч буй аж.

Тиймээс “Pokemon Go” тоглохыг хязгаарлах шийдвэрийг Хятад, Ираны Засгийн газар гаргасан байна.

Энэ бүх тоо баримт, тогтоол шийдвэрүүд тус тоглоом дэлхий дахиныг хэрхэн байлдан дагуулсныг гэрчлэх хангалттай баталгаа. “Pokemon Go” нь зөвхөн тоглоом сонирхогчдыг эрхшээлдээ оруулаад зогсохгүй мөнгөн урсгалыг ч соронз шиг сорсон. Тоглоом нээлтээ хийснээс хойш гурван сарын дотор нийт 600 сая ам.долларын орлогыг олсон байна. Цаашлаад “Pokemon Go” нь “Nintendo” компанийн үнэ цэнэ долоон тэрбум ам.доллар болтлоо өсөхөд нөлөөлсөн гэх мэдээлэл бий.

Ер нь нийгмийн сүлжээнд зориулсан тоглоомын Японы “Nintendo” компанийн ашиг, орлогын үзүүлэлт сүүлийн жилүүдэд үлэмж ахисан. Ком-

БАНК САНХҮҮ

3.9 сая төлбөрийн карт ашиглаж байна

Г.Ану
ЗГМ

Монгол Улсад өдөрт дунджаар 7.7 тэрбум төгрөгийн 179.7 мянган гүйлгээг төлбөрийн картаар хийж байна. Төв банкны мэдээлснээр 2016 онд банк хооронд 2.8 их наяд төгрөг, 65.6 сая ширхэг картын гүйлгээ хийжээ. Улсын хэмжээнд нийт 3.9 сая төлбөрийн карт эргэлтэд байгаа. Үүний 70.5 хувийг нийслэл, 29.5 хувийг орон нутагт ашиглаж байгааг төв банкнаас мэдээллээ.

Бэлэн бус төлбөрийн картыг ашиглан үйлчилгээ үзүүлдэг 28.8 мянга төхөөрөмж идэвхтэй хэрэглэгдэж байгаагаас дийлэнх нь буюу 73.8 хувь үйлчилгээний газруудад байрладаг POS терминал төхөөрөмжүүд байна. Үүнтэй ижил төстэй, жижиглэн худалдаа эрхлэгчдэд зориулсан хөдөлгөөнт POS терминал болох MPOS хэрэглээнд өргөн нэвтэрчээ. Ухаалаг гар утас болон таблетад холбогддог 3796 ширхэг MPOS терминал ашиглаж байгаа нь энгийн POS терминалаас тав дахин цөөн байгаа ч бэлэн мөнгө авах зориулалттай АТМ-ийн тооноос хоёр дахин өндөр үзүүлэлт.

панийн шилдэг цувралуудын нэг жирэвгэр сахайт “Super Mario”-г мартаж болохгүй. Саад бүрийг давахыг хичээдэг “Super Mario” компанийн санхүүгийн байдалд ч эергээр нөлөөлжээ. Ийнхүү 20 жилийн өмнө олон нийтийн сонирхлыг татаж байсан баатрууд өнөөдөр Японы “Nintendo” компанийг ухаалаг төхөөрөмжид зориулсан видео тоглоомын хамгийн хүчирхэг компанийн нэг болгоод байна.

Өөрөөр хэлбэл, ухаалаг төхөөрөмжөөс хэт хамаатай болсон орчин цагийн дэлхийд видео тоглоомын байлдан дагуулалт үргэлжилж байгаа нь энэ. Сүүлийн хэдэн жил дэлхий нийтийг “амт”-нд умбуулсан “Candy Crush”-ийг мэдэхгүй хүн ховор. Амтат чихрүүд тоглоомыг түгээгч “King” компанийн зах зээлийн үнэлгээг зургаан тэрбум ам.долларт хүргэсэн түүх бий.

Бидний амьдралд үлэмж байр суурь эзлэх болсон ухаалаг утасны хэрэглээ, хил хязгааргүй нийгмийн сүлжээ нь энэ төрлийн тоглоом хөгжих, дэлхий даяар түгэх таатай орчин болсныг суллаачид тэмдэглэж байна. Гар утас нийтийн хэрэглээ байсан цагт тоглоомын хэрэглээ алга болохгүй гэдгийг ч мэргэжилтнүүд тэмдэглэж байгаа. Энэ хэрээр тус салбарыг чиглэх хэрэглэгчид хийгээд хөрөнгийн урсгал нэмэгдэхээр байгаа. Үүнээс үүдэн ухаалаг төхөөрөмжид зориулсан тоглоомын зах зээлийг технологийн талбар, мөнгөний авдар хэмээн тодорхойлоод байна.

Тэгвэл энэ ирээдүйтэй атлаа сонирхолтой зах зээлд монгол залуус мэдлэг, чадвараа уралдуулаад эхэлжээ. “Startup Mongolia” төрийн бус байгууллагын мэдээлснээр нийгмийн сүлжээнд зориулсан видео тоглоом хөгжүүлэгч цөөнгүй залуу манайд бий. Тэдэн дундаас хамгийн амжилттай ажиллаж буй нь “Alchemist Technologies”. Өдгөө гурав дахь тоглоомоо өлгийдөн аваад буй тус компани хэдийнэ олон улсад бүтээгдэхүүнээ гаргаад эхэлсэн. Анх жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан “Honey” нэртэй борлуулалтын цахим тооцооны дэвтэр зохион бүтээсэн залуус өдгөө бүтээгдэхүүний төрөл, зах зээлээ тэлжээ.

“Alchemist Technologies” хоёр сар гаруйн өмнөөс “Mars Challenge” тоглоомоо хэрэглэгчдэд хүргэсэн байна. Залуус шинэ тоглоомоо “Mars Challenge” буюу “Ангарагийн сорилт” нэртэй борлуулалтын цахим тооцооны дэвтэр зохион бүтээсэн хэмээн нэрлэсэн нь учиртай. “Тус тоглоомыг бүтээхээр зэхэж байсан үе буюу өнгөрсөн онд дэлхийн технологийн ирээдүйг тодорхойлогч Элон Макс түргүүтэй тэрбумтнууд Ангарагийг эзлэн авна, тус гарагт амьдрал эхлүүлнэ гэсэн мэдэгдэл эрчимтэй хийж эхэлсэн. Энэ нь огторгуй руу нисэх, түүнийг сонирхох хүмүүсийн хандлагыг нэмэгдүүлнэ гэж үзсэн учраас тоглоомоо зохиосон” гэж “Alchemist Technologies” компанийн захирал Х.Хангай тайлбарлав. Зах зээлд мэндлээд удаагүй ч тус тоглоомыг өдөрт дунджаар 800 хүн тоглож байгаа. Цаашид уг бүтээлээ илүү олон хүнд хүргэхээр ажиллаж буйгаа тэрбээр дуулгав.

Үүнээс гадна тус компани “Forgotten warrior” буюу “Мартагдсан дайчин” тоглоомоо танилцуулаад байгаа. ОХУ,

Туркийн зах зээлд зориулан гаргаж буй энэ тоглоомын гол дүрээр эдгээр улсад алдартай эртний баатруудыг сонгожээ. Энэ нь хойд хөрш болон турк хэрэглэгчдийг татаад байгаа аж.

Компани шууд худалдан авалт болон зар сурталчилгаанаас орлого олдог. Олон улсын “Google” зэрэг компани зар сурталчилгааг нь байршуулдаг байна. “Бид хөгжүүлэлтээ хийснээс хоёр жилийн дараа эхний орлогоо олсон. Тэр хүртэл ашиг, орлого олоогүй. Энэ хугацаанд зах зээлийн судалгаа, туршилт, хөгжүүлэлт хийсэн. Алдсан зүйл ч их бий хэмээн Х.Хангай ярилаа. Тууштай байж чадвал тогтмол орлого олох боломжтой талбар. Тоглоом бол дэлхийн хил хязгааргүй зах зээлд гарах хамгийн хурдан гарц гэж тэрбээр үзэж байна. Гэхдээ бизнесээ хөгжүүлэхэд боловсон хүчний асуудал тулгардгийг Х.Хангай нуусангүй. Тус компанийн боловсон хүчний дийлэнх нь Монголд их, дээд боловсрол эзэмшсэн аж.

Хөгжүүлэлтээ хийснээс хоёр жилийн дараа эхний орлогоо олсон

Монгол залуус ажиллаж, хөдөлмөрлөхөөр хилийн чанадыг зорих нь олширсон. Миний бодлоор гадаадад ажиллахгүйгээр Монголдоо бүтээж, олон улсын зах зээлд гаргах боломжтой. Нэг хувилбар нь энэ. Тиймээс тууштай ажиллаж байгаа. Ер нь тууштай байж

чадвал Монгол бол технологийн бизнест харьцангуй таатай улс. Гол нь сайн бүтээгдэхүүн гаргах хэрэгтэй хэмээн “Alchemist Technologies”-ийн залуус ярьж байна. Тиймээс ч хилийн чанадыг зорилтот зах зээлээ болгож, түүнд зориулсан бүтээл хийгээд буй нь энэ.

Дэлхий дахинд энэ төрлийн тоглоом нь зөвхөн арилжаа, сурталчилгаанаас орлого олоод зогсохгүй. Тоглоомын дүрүүдийн нэр, үг хэллэг, хувцас, хэрэглэл нь мөн орлогын нэг хэлбэр болдог байна. Хэдхэн жилийн өмнө олны хүртээл болсон Ууртай шувуудын түүх өнгөрсөн онд бүрэн хэмжээний хүүхэлдэйн кино болж, үзэгчдийн хүртээл болсныг та санаж байна уу. Өнгөрсөн оны тавдугаар сард нээлтээ хийсэн “Angry Bird” хүүхэлдэйн кино олон улсын зах зээлээс нийт 350 сая ам.долларын орлого олсон байна. Ингээд бодохоор дэлхий нийтийг шуугиулдаг тоглоомын зах зээл нь яах аргагүй мөнгөний авдар гэж болохоор.

Одоогийн байдлаар ухаалаг төхөөрөмжид зориулсан тоглоомын бизнес 10 тэрбум ам.доллараар хэмжигддэг гэх мэдээлэл бий. Тиймээс энэ салбарыг чиглэх мөнгөний урсгал нэмэгдэж байна. “Dove”, “Clear”, “Lipton” зэрэг бүтээгдэхүүнээр бидний сайн танил “Unilever” компани өнгөрсөн сард гэхэд ухаалаг төхөөрөмжид зориулсан тоглоомын бизнест хөрөнгө оруулахаар болжээ. Мөн бидний хуучин танил “Nokia” компани энэ төрлийн тоглоомын бизнестээ эргэн ирж буйгаа зарлав.

Ийнхүү энэ салбар технологийн шинэ талбар, мөнгөний авдар болон хувирлаа. Харин эрчээ авч буй энэ өрсөлдөөнд монголчууд бид оролцох боломж харагдаж байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» БАНК, САНХҮҮ

759.7

Тэрбум төгрөг. Монголбанкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 759.7 тэрбум төгрөг болов.

» АРИЛЖАА

1.19

Хувь. Монголын хөрөнгийн биржийн индекс 847.19 нэгж болж, 1.19 хувиар буурав. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 1.4 их наяд төгрөгтэй тэнцлээ.

» УУЛ УУРХАЙ

34.3

Тэрбум төгрөг. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрт өнгөрсөн онд 34.3 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

» ФОРУМ

Монголын эдийн засгийн чуулган энэ сарын 30-31-нд “Тогтвортой бодлого, хариуцлагатай түншлэл” сэдвийн дор Төрийн ордонд болно.

» ГАДААД ХУДАЛДАА

36.3

Сая ам.доллар. Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ энэ оны эхний хоёр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36.3 хувиар буюу 350.9 сая ам.доллараар өсчээ.

» СУДАЛГАА

58.9

Хувь. Өрхийн хэрэглээ дотоодын нийт бүтээгдэхүүний 58.9 хувийг эзэлж, зах зээлийн хамгийн том худалдан авагч болж байна.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

163

Компани. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 163 нээлттэй компани байна.

» ОРОН НУТАГ

Зүүн бүсийн Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг дотоодын нийт бүтээгдэхүүний зургаа орчим хувийг бүрдүүлж байна. Бусад бүстэй харьцуулахад нэг хүнд ногдох ДНБ харьцангуй өндөр байгааг “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс онцоллоо.

» ХӨРШ

69

Хувь. Манай улс нийт бараа эргэлтийн 69 хувь буюу 907.6 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай хийж байна.


» **САНХҮҮГИЙН ТОЛЬ**
Өгөөжийн хувь-Rate of return-Хөрөнгө оруулалтаас олох ашиг бөгөөд хөрөнгө оруулсан дүнгийн хувиар жилийн үндсэн дээр тооцно.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2458.10
Евро	2647.37
Япон иен	21.83
ОХУ рубль	42.93
БНХАУ юань	355.99
БНСУ вон	2.20

Эдийн засаг

WTI-ийн ханш 10 хувиар буурлаа



WTI төрлийн газрын тосны ханш сүүлийн нэг сард (ам.доллараар)

West Texas төрлийн газрын тосны ханш нэг сарын хугацаанд 10 хувиар буурлаа. Ингэснээр долдугаар сараас хойших нэг сарын хамгийн огцом уналтад тооцогдож байна. Даваа гарагт ханш олон улсын зах зээлд 0.9 хувиар суларч, 48 ам.долларт хүрсэн.

АНУ-ын түүхий газрын тосны олборлолт 1982 оноос хойших дээд цэгт хүрсэн. Албан

мэдээллээр тус улсын долоо хоногийн түүхий газрын тосны нийлүүлэлт 8.2 сая баррелийг давжээ. Нийлүүлэлт ийн өссөнөөс үүдэн WTI-ийн үнэ сулав.

Тэрчлэн Лондоны металлын биржид үйлдвэрлэлийн металлын ханш уруудлаа. Тухайлбал, зэсийн ханш 0.6 хувиар буурсан. Харин алтны ханш 0.4 хувиар чангарч, унци нь 1234 ам.доллартай тэнцэв. [3ГМ]

[ЗАСГИЙН ГАЗРЫН] МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД						
НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	62.39	▼ -0.86%	3/20/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.041	▼ -2.38%	3/20/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	23.75	▼ -12.04%	3/20/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.023	▲ +4.55%	3/20/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	3/20/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.4	▲ +2.33%	3/20/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.28	▼ -1.83%	3/20/2017
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.35	▲ +3.92%	3/20/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.21	▼ -4.55%	3/20/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.69	▼ -2.82%	3/20/2017

ТҮҮХИЙ ЭД					
НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1235.27	▲ +0.49%	3/20/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	967.8	▲ +0.5%	3/20/2017
МӨНГӨ	SIA	унци	17.445	▲ +0.18%	3/20/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	267.6	▼ -0.58%	3/20/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	90.09	▲ +0.69%	3/20/2017
WTI ТОС	CLA	баррель	48.42	▼ -0.74%	3/20/2017
БРЕНТ	COA	баррель	51.54	▼ -0.43%	3/20/2017
БЕНЗИН	XBA		158.86	▼ -0.64%	3/20/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.909	▼ -1.32%	3/20/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	3/20/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	82.25	▲ +0.73%	3/20/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.181	▼ -0.44%	3/20/2017
БУДАА	RRA	центнер	9.935	▲ +0.2%	3/20/2017
БУУДАЙ	WA	бушель	441	▲ +1.09%	3/20/2017
КАКАО	CCA	тонн	2013	▼ -0.69%	3/20/2017
КОФЕ	KCA	фунт	1.420	▲ +0.42%	3/20/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ					
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО	
АПУ ХК	APU	340.13	▼ -3.28%	3/20/2017	
ГОВЬ ХК	GOV	12960	▼ -2.11%	3/20/2017	
МИК ХОЛДИНГ ХК	MIK	11840	▼ -1.25%	3/20/2017	
МАХ ИМПЕКС ХК	MMX	2456	▼ -1.29%	3/20/2017	
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	20520	◀▶ 0%	3/20/2017	
СҮҮ ХК	SUU	130.49	▼ -3.92%	3/20/2017	
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	20020	▲ 0.1%	3/20/2017	
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2349	▼ -1.3%	3/20/2017	
АРИГ ГАЛ ХК	EER	2300	◀▶ 0%	3/20/2017	
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	132.37	▼ -5.45%	3/20/2017	
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HRM	136	▼ -9.31%	3/20/2017	
ЖЕНКО ТУР БЮРА ХК	JTB	54.8	▲ 4.34%	3/20/2017	
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	531.07	▼ -4.31%	3/20/2017	
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК	MDR	425	◀▶ 0%	3/20/2017	
МОНГОЛ НЭХМЭЛ ХК	MNH	4480	▲ 14.84%	3/20/2017	
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	367.09	▼ -5.87%	3/20/2017	
МЕРЕКС ХК	MRX	89	▼ -1.11%	3/20/2017	

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД					
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5900.997	+0.24	◀▶ 0.00%	3/20/2017
DAX INDEX	DAX	12095.24	+12.06	▲ +0.1%	3/20/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15490.49	-71.92	▼ -0.46%	3/20/2017
S&P/ASX 200	AS51	5778.907	-20.74	▼ -0.36%	3/20/2017
S&P 500	INX	2378.25	-3.13	▼ -0.13%	3/20/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3250.808	+13.36	▲ +0.41%	3/20/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20914.62	-19.93	▼ -0.1%	3/20/2017
TOP 20	MSETOP	13023.73	-54.96	▼ -0.42%	3/20/2017
FTSE 100	UKX	7424.96	+9.01	▲ +0.12%	3/20/2017
HANG SENG	HSI	24448.02	+138.09	▲ +0.57%	3/20/2017
NIKKEI 225	NKY	19521.59	-68.55	▼ -0.35%	3/20/2017

ШИЛДЭГ КОМПАНИУД ШИЛДЭГ УДИРДАГЧИД



Дэлхийн тэрбумтнууд, Монголын бизнесийн шилдгүүдийн талаар сонирхолтой нийтлэл, ярилцлагуудыг цаг алдалгүй эрхэм уншигчдадаа хүргэж байдаг Forbes сэтгүүлийн 2017 оны шинэ дугаар гарсныг дуулгахад таатай байна.

Хаяг: Блю Скай тауэр, 4 давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, I хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс
sales@forbesmongolia.mn | Утас: 77074646

Mongolia
Forbes



КАЗАХСТАН РУУ **70₸**-ӨӨР ЯРИАРАЙ
НАУРЫЗЫН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮҮЛЬЕ!

Урамшууллын хугацаа
2017.03.15-24

2222

1800-2222

Бусад сүлжээнээс

www.mobicom.mn



Од гарц, Глобус карт, Глобус үйлчилгээгээр 2017.03.15-наас 2017.03.24 хооронд Казакстан руу Мобикомын сүлжээн дэх тариф буюу 70 төгрөгөөр ярих боломжтой боллоо.